



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМ



СУМЫН ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ
(2014 - 2024 ОН)



Улаанхус сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Засаг дарга Ж. Сламбол ахлагчтай сумын Төлөвлөл, хялалтын хороо, ЗДТГ-ын дарга А. Хоньрат ахлагчтай



ажлын хэсэг хамтран 2014 оны 5 дугаар сард сумын төв Билүүд боловсруулав. Төлөвлөгөөг сумын Төлөвлөлт, хяналтын хороо, Ажлын хэсгийн хамтарсан үр дүнгийн семинараар 2014 оны 3 дугаар сарын 24-нд хэлэлцэж сайшаав. Хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын-10 -ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж батлав. Тогтоолын дугаар 02



БАЯН ӨЛГИЙ аймгийн УЛААНХУС сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө нь тус сумын төр, нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн хамтын бүтээл бөгөөд өмчлөх, зохиогчийн эрх тус суманд хадгалагдана. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төлөвлөлт, хяналтын хороо жил бүр хэлэлцэж, төлөвлөгөөний явцыг үнэлэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох байдлаар сайжруулж байна.

УЛААНХУС сумын хөгжлийн энэхүү төлөвлөгөөг Мерси Кор олон улсын байгууллага, Нутгийн удирдлагын холбоо, USAID байгууллагын төслийн хүрээнд арга зүй, зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав.

Зөвлөх баг: О. Саруул, Н. Айдолда

Боловсруулсан газар Билүү 2014 он

Гарчиг / Хуудсыг дугаараар нь харуулах /

ӨМНӨХ ҮГ ОРШИЛ

Нэгдүгээр бүлэг: СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

- 1.1. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүй
 - 1.1.1. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, үйл явц, арга зүй
 - 1.1.2. Төлөвлөгөө боловсруулах үндэслэл, шаардлага
- 1.2. Зохион байгуулалт ба зохицуулалтын арга хэмжээ
 - 1.2.1. Төлөвлөлт, хяналтын хороо
 - 1.2.2. Ажлын дэд хэсэг

Хоёрдугаар бүлэг: СУМЫН ХӨГЖЛИЙН ОРЧНЫ ОДООГИЙН БАЙДАЛ

- 2.1. Баян- Өлгий аймгийн Улаанхус сумын танилцуулга
 - 2.1.1. Сум байгуулагдсан түүх



- 2.1.2. Ус, усны амьтан, газрын гадарга, цаг уур
- 2.1.3. Байгалийнбаялаг, түүхдурсгалынболонүзэсгэлэнтгазрууд
- 2.2. Нутгийн удирдлагын зохион байгуулалт**
- 2.2.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага
- 2.2.2. Нутгийн захиргаа
- 2.3. Хүний нөөц, амьжиргааны чадавхи**
- 2.3.1. Хүн амын үзүүлэлтүүдийн хандлагын судалгаа
- 2.4. Эдийн засгийн үндсэн салбарууд**
- 2.4.1. Мал аж ахуй
- 2.4.2. Газар тариалан
- 2.4.3. Орон нутгийн төсөв
- 2.4.4. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- 2.4.5. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ
- 2.4.6. Дэд бүтэц
- 2.5. Албан байгууллагын товч танилцуулга**
- 2.5.1. Боловсролын салбар
- 2.5.2. Соёлын үйлчилгээ
- 2.5.3. Эрүүл мэндийн үйлчилгээ
- 2.6. Иргэд, оролцогч талуудын оролцооны үнэлгээний дүн Ажлын хэсэг**
- 2.6.1. Бизнес орчны судалгааны дүгнэлтүүд
- 2.6.2. Свот шинжилгээний матриц, дүгнэлтүүд

Гуравдугаар бүлэг: СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- 3.1. Хөгжлийн алсын хараа , сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл
- 3.2. Сумын хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хангах зорилго, зорилтууд
- 3.3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг
- 3.4. Хөрш зэргэлдээ сумдтай хамтран ажиллах
- 3.5. Сумын хөгжлийн зорилго, зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн тойм

Дөрөвдүгээр бүлэг: ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

- 4.1. Гол үр дүнгийн шалгуур үзүүлэлт
- 4.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт
- 4.3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудлын зохицуулалт

Тавдугаар бүлэг: ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. Хяналтын хэлбэр ба зохион байгуулалт
- 5.2. Хяналтын үнэлгээний арга хэлбэр, үе шат, тайлагнах тогтолцоо

Зургаадугаар бүлэг: ХАВСРАЛТУУД

- 6.1. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө,
- 6.2. Төлөвлөгөөний хүрээнд 2014-2024 онд хэрэгжиж эхлэх төсөл, үйл ажиллагаа
- 6.3. Мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны төлөвлөгөө,
- 6.4. 2014 – 2024 онд хэрэгжиж дуусах төсөл, үйл ажиллагаа
- 6.5. 2014 – 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хийх мониторингийн төлөвлөгөө



6.6. Төслийн танилцуулга

Товчилсон үгийн жагсаалт

ИТХ	-Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	-Засаг даргын Тамгын газар
ТББ	-Төрийн бус байгууллага -
ОНЭЗХ	-Орон нутгийн эдийн засгийн хөгжил
ТХХ	-Төлөвлөлт хяналтын хороо
ХАА	-Хөдөө аж ахуй
МАА	-Мал аж ахуй
ААНБ	-Аж ахуйн нэгж, байгууллага
ЖДҮ	-Жижиг, дунд үйлдвэр
ОУ	-Олон улс
ГТХАН	-Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг
ОХУ	-Оросын Холбооны Улс
FM	-Богино долгионы радио нэвтрүүлэг
ХХК	-Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Га	-Гектар
ТХГН	- Тусгай хамгаалалттай газар нутаг

ОРШИЛ

Сумын хөгжлийн ирээдүйд хүрэхийн тулд зайлшгүй төлөвлөн хэрэгжүүлэх сумын хөгжлийн төлөвлөгөөний үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн тогтвортой түншлэл, оролцогчдын хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурлан зөв тодорхойлох, хэрэгжүүлэх явдал сумын олон нийтийн төсөөлж буй цорын ганц арга зам гэдгийг бид баттай ойлголоо. Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад оролцооны арга хэрэглэсэн явдал үйл ажиллагааны төлөвлөлтийн өмнөх арга барилаас салж, орон нутгийнхаа оролцоо, чин эрмэлзэлд тулгуурласан шинэлэг хэлбэрийг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэх том сургууль болсныг онцлон тэмдэглэж байна.

Зөвшилцөл, хэлэлцүүлэг, хамтын шийдвэр, нээлтэй ярилцлага зэрэг оролцоог хангах арга хэлбэрийг төлөвлөгөө боловсруулахад өргөн ашиглав, хариуцах шинэ бүтцээр дамжуулан бүх шатанд хэрэгжүүлээ.

Манай иргэд байгууллагууд хөгжлийн төлөвлөгөөнөөс ихээхэн зүйлийг хүсэн хүлээж байгаа нь дотоод, гадаад боломж, давуу талаа улам дайчлан төсөөлж буй алсын хараандаа хүрэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна. Мөн сул тал,саад бэрхшээлийг амжилттай даван туулахын төлөө шаргуу ажиллах ёстойг тодорхойойлгон ажиллаж байна. Гэхдээ нөөц бололцоо,чадавхиа зангидан ашиглаж, өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийхийн төлөө тууштай ажиллах болно гэдгээ төрөлх нутаг усныхаа хөгжил цэцэглэлт, бизнесийн орчинг төгөлдөржүүлэн сайжруулахад зохих дэмжлэг үзүүлж ирсэн, дэмжин туслахыг чин сэтгэлээсээ сонирхож буй сумынхан, түншүүд, дэмжигчиддээбат илэрхийлэх нь зөв гэж үзэж байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө нь манай сумын бүтээл, бидний өмч болно.

Үзэл баримтлалын энэ хүрээнд авч үзвэл эдийн засгийн өсөлт бий болгож тогтворжуулан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, байгаль орчноо хамгаалах, иргэдийнхээ амьжиргааны түвшинг сайжруулах зэрэг хөгжлийн зангилаа асуудлыг шийдвэрлэх, сум орны цаашдын хөгжил дэвшлийн баттай эхлэл болсон нэн тэргүүний асуудлыг тодорхойлж өгсөн нь онцлог болсон гэж үзэж байна. Сумын хөгжил цэцэглэлтийн тусын тулд бодитой дэмжлэг үзүүлэх чиглэлээр хандивлагч, хөрөнгө оруулагч, иргэд байгууллагын зүгээс зөв санал, үйл ажиллагааг бид ямагт талархан хүлээн авч хамтран ажиллахад чин эрмэлзэл дүүрэн байгаагаа илэрхийлж байна.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
УЛААНХУС СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2014 оны 4 дүгээр сарын 10 - ны өдөр

Дугаар02

Билүү төв.

**Сумын хөгжлийн цогцолбор төлөвлөгөө
батлах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. “А”-д заасныг үндэслэн сумын хөгжлийн 2014-2024 оны цогцолбор төлөвлөгөөний төслийг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. Улаанхус сумын хөгжлийн цогцолбор төлөвлөгөөг зургаан бүлэгтэйгээр баталсугай.
2. Хөгжлийн төлөвлөгөөг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг даргад даалгасугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төлөвлөлт, хяналтын хороогоор жил бүр хэлэлцэн, нэмэлт өөрчлөлтийг тухайн бүр нь оруулан, тодотгол хийж ажиллаж байхыг үүрэг болгосугай.

ДАРГА



Н. АЙДОЛДА



УЛААНХУСЧУУДЫН ХӨГЖЛИЙН САНААЧИЛГЫГ АЙМАГ ДЭМЖИНЭ



Эдийн засаг, нийгмийн хөгжлийн залгамж чанарыг хангах зорилгоор хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийг сумынхаа онцлогт тохируулан боловсруулах нь нутгийн удирдлага, төрийн байгууллагын тулгамдсан асуудлын нэг болж байна. Энэ цаг үед Улаанхус сумын ИТХ, ЗДТГ, ард иргэд хамтран сумынхаа “Хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулан гаргаж байгаа нь ихээхэн ач холбогдолтой юм.

Өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагийн хөгжлийг бодитойгоор судлан үнэлэлт, дүгнэлт өгч сумынхаа хөгжлийн гарц, алсын хараа,

тэргүүлэх чиглэлээ тодорхойлон хөтөлбөр төслүүдээр томъёолон гаргасан нь Хөгжлийн төлөвлөгөөг илүү ойлгомжтой, хэрэгжих үндэслэлтэй болохыг харуулж байна.

Сумын хөгжил айл өрхөөс, Аймаг, Улсын хөгжил сумаас эхтэй учраас Улаанхусчуудын энэхүү хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг бодитой ажил болгоход Баян Өлгий аймгийн төрийн байгууллагууд, олон нийт дэмжин ажиллана гэдгээ илэрхийлж байна. Байгалийн үзэсгэлэнт газар нутаг, хүн ам, мал сүргээрээ манлайлдаг Улаанхус сумын ард түмэн та бүхэнд өөрсдийн боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөг бодит ажил болгоход нэгдмэл хүч санаа бодолтой, нэгэн үзүүрт сэтгэлээр хамтран ажиллаж амжилтанд хүрэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай

**БАЯН ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,
УЛААНХУС СУМЫН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

Х. ДАРМЕН



ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА АЖИЛЛАЦГААЯ



Улаанхус гэдэг нэр нь Монгол улсын хөгжлийн түүхэнд 1922 оны эхээр тодорч өнөөдөр хүн бүхний мэдэх Улаанхус сум болсон билээ.1860-аад онд казах иргэд Хятадын Шиньжанаас анхлан нүүж ирж оршин тогтнож ажил амьдралын өрнүүн хөдөлгөөн, халуун дулаан уур амьсгал оргилуулан, олон жилийг элээсээр өнөөдөртэй золгож байна. Энэ хугацаанд бид бүхнийг маань уламжлан удирдаж ирсэн үе үеийн удирдлагууд, ажил амьдралынхаа түүхээр холбогдсон бүх хүмүүс, Улаанхусаар овоглосон сумынхаа хөгжлийн түүхийг бүтээлцэж яваа эрхэм та бүхэндээ сумын ИТХ-ын нэрийн өмнөөс болон хувиасаа мэндчилгээ хүргэж чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Сумын 2014-2024 он хүртэлх хөгжлийн зорилго нь: Хүний хөгжилд тулгуурласан нийгэм эдийн засгийг хослуулан амьжиргааны түвшинг тууштай дээшлүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай өндөр технологид суурилсан тэргүүлэгч чиглэл бүхий хөгжлийн төв болох явдал юм. Төлөвлөгөө нь амьдралын явцад боловсронгуй болж, баяжигдах баримт бичиг бөгөөд тусгагдсан хөтөлбөр төслүүдийг бүх хүн, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран бодит үр дүнтэй хөрөнгө оруулалтын ажил болгож хэрэгжүүлсэнээр иргэдийн амьдрал ахуй, амьжиргааны түвшинд өөрчлөлт гарч бүтээн байгуулалтууд болж үлдэх ёстой. Уг төлөвлөгөөг боловсруулах ажлыг хариуцан ажилласан Төлөвлөлт Хяналтын Хороо, Ажлын хэсэг зохион байгуулж, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн Нутгийн Удирдлагын Холбоо, Мерси Кор Олон Улсын Байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Улаанхусчууд та бүхнийг нутгийн сүлд хийморь ивээх болтугай.

СУМЫН ИТХ-ЫН ДАРГА

Н.АЙДОЛДА



БИДНИЙ ИРЭЭДҮЙ ӨӨДРӨГ БАЙХ ЁСТОЙ



Сумын урт хугацаанд хөгжүүлэх 2014-2024 оны цогцолбор төлөвлөгөөг боловсруулан эмхтгэж гадаад, дотоодын хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэгчид, бизнес эрхлэгчид, эрдэм шинжилгээний ажилчид, сумын уугуул иргэд, ард иргэд та бүхэндээ өргөн толилуулж байгаадаа нэн баяртай байна.

Энэхүү удаан хугацааны цогцолбор төлөвлөгөө нь олон нийтийн санаа бодолд тулгуурлахт оролцооны аргын зарчмыг баримталж, давуу болон сул талаа бодитой үнэлсэн хөгжил дэвшилд хүрэх арга зам нь тодорхой, байгаль орчин хүн ардаа өргөн дээдэлж, бүс нутаг, орон нутгийнхаа онцлогт тулгуурлан эдийн засгийг хөгжүүлэх нөөц боломжоо тооцсон баримт бичиг болсноороо онцлогтой юм. Гадаад дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчид, хандивлагчид, энэхүү төлөвлөгөөнд анхаарлаа хандуулж буй нийт хүмүүс ээ:

Улаанхус сумын хөгжлийн цогцолбор төлөвлөгөөг өргөн барьснаар та бүхэн бидэнтэй хамтран ажиллах үйл ажиллагаа, хүрэх үр дүн тань тодорхой болж, манай сумынхны нээсэн хаалгаар итгэл төгс морилон орно гэдэгт итгэлтэй байна.

Сумын ард иргэд ээ. Та биднийг хүсэн хүлээж, хүрэхийг төсөөлөн эрмэлзэж байсан хэтийн ирээдүй, хөгжил дэвшлийн шинэ эхлэл хүлээж байна. Сумынхаа ирээдүйг харж үр хүүхдийнхээ сурах, амьдрах, хүмүүжих сайхан нөхцлийг бүрдүүлэх алхам болсон энэхүү цогцолбор төлөвлөгөөг байгаль орчноо дээдлэх хүн хүнээ хайрлах, идэвхтэй ажил хэрэгч сэтгэлээр хүлээн авч өөрийн амьдрал ахуйн нэгээхэн удирдлага болгохыг та бүхэнд уриалж байна.

Энэхүү төлөвлөгөө нь орон нутгийн иргэд та бүхний өмч бөгөөд цаг үеийн хувьд цаашид олон түмэн, та бүхний оюун билэг, санаа сэтгэлээр улам баяжигдан жил бүр шинэчлэгдэж байх ёстойг тэмдэглэн хэлэх хэрэгтэй юм.

Сайн үйлс бүхэн дэлгэрч байхын өлзийтэй ерөөлийг дэвшүүлье


СУМЫН ЗАСАГ ДАРГА

Ж. СЛАМБОЛ



Нэгдүгээр бүлэг: СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

1.1. Хөгжлийн ноцолбор төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүй



1.1.1. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, үйл явц, арга зүй

Сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах үндсэн зарчим нь олон нийтийн оролцоон дээр тулгуурлах явдал байсан. Олон нийтийн оролцоо нь олон янзын хэлбэр, түвшинд байсан бөгөөд зарим нь мэдээлэл өгөх, солилцох, зөвлөгөө өгөх хэлбэртэй байсан бол зарим нь хамтран ажиллах, шийдвэр гаргах хэмжээнд байсан. Оролцогчдын ажил, мэргэжил, нас, хүйс, ажлын дадлага, туршлага зэрэг нь харилцан адилгүй байсан ч хамгийн гол нь сумын хөгжлийн талаарх бүх талын мэдээллийг бүрэн дүүрэн авах зорилгоор олон янзын бүлгийн хүмүүстэй уулзаж ярилцан санал бодлыг нь сонсов. Оролцогчдыг хүндэтгэх, идэвхжүүлэх үүднээс тэдэнд уулзалтын урилга явуулах, очиж уулзах, бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах, санал асуулгын хуудас бөглүүлж саналыг нь авах, статистик үзүүлэлтийн судалгаа авах, хүүхдүүдийн дунд зохион бичлэгийн уралдаан зохион байгуулах зэргээр санал солилцох, зөвлөлдөх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгууллаа.

Бүлгийн ярилцлагыг төлөвлөлт, хяналтын хорооны гишүүд, ахмадууд, залуучууд,



эмэгтэйчүүд, тамгын газрын ажилтнууд, бизнес эрхлэгчид, сургуулийн сурагчид гэсэн бүлгүүдээр зохион байгуулсан нь зохих үр дүнгээ өгсөн. Давхардсан тоогоор нийт **1980** хүнтэй уулзаж, саналыг нь авч төлөвлөгөө боловсруулахад тусган ажиллав.

- Нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг нэгтгэх замаар сумын хөгжлийн алсын хараа, нийтлэг зорилго, зорилтуудыг тодорхойлох
- Бизнесийн орчноор дамжуулан сумын төр, захиргаанаас үзүүлэх дэмжлэгтэй холбоотой хөтөлбөр, төслүүдийг оролцогчдын туршлага мэдлэг, санал төсөөлөл дээр үндэслэн тодорхойлох
- Мастер төлөвлөгөөг орон нутгийн нөөц бололцоо, бүс нутгийн хөгжлийн талаархи урьд боловсруулсан төсөл хөтөлбөртэй нягт уялдуулж авах гээхийн ухаанаар хандах

Мастер төлөвлөгөөг хандивлагчид, хөрөнгө оруулагчдад хандах, нөлөөлөх арга хэрэглүүр болгон ашиглахаас гадна дотоод нөөц боломжийг нээн ашиглахад чиглүүлэх

Төлөвлөгөө боловсруулах үндсэн шаардлага.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги” зэрэг бодлогын чанартай баримт бичгийг батласны зэрэгцээ “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг батлан гаргасан байна. Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар “Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг боловсруулан Монгол улсын Их хурлаас батласан билээ. Эдгээр баримт бичгүүдэд тодорхойлсон зорилго, зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлэх, бүс нутгийн болон сум, орон нутгийн хөгжлийн бодлогыг тэдгээртэй уялдуулах шаардлага тавигдаж байна. Энэ зорилгыг хэрэгжүүлэх үүднээс Улаанхус сумын хамт олон өөрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсрууллаа.

“Мерси кор” олон улсын байгууллагын Нутгийн Удирдлагын холбооны төсөл нь бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд зохих дэмжлэг үзүүлэхээ санал болгосон нь төлөвлөгөө боловсруулах таатай нөхцөлийг зарим талаар бүрдүүлж өгсөн болно.

Сумын олон нийтийг оролцуулан олон удаагийн семинар, ярилцлага, уулзалт зохион байгуулж, одоогийн байдлаар суманд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон гаргав.

Төлөвлөгөөний хамрах үе шат Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө 2014-2024 оны хугацаанд хамран хэрэгжих бөгөөд хугацааны хувьд гурван үе шаттай байна.

Эхний үе шат -2014-2016 он Хөгжлийн суурь орчинг бүрдүүлэх үе

Хоёр дах үе шат -2017-2021 он Эрчимтэй хөгжлийн үе

Гуравдах үе шат -2020-2024 он Тогтвортой хөгжлийн үе

1.1.3. Төлөвлөгөөний зорилго, зорилтууд:

Улаанхус сумын эдийн засгийн хөгжлийн цогцолбор төлөвлөгөө дараах зорилгод чиглэгдэж байна.

1. Сумын нийгэм, эдийн засгийг төр засгийн бодлогод нийцүүлэн уялдаа холбоотой, тэнцвэртэй хөгжүүлэх.
2. Орон нутгийн онцлог байдалд тохирсон хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлох.
3. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлж, байгаль орчны зохистой цогцбодлого явуулснаар бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэх.
4. Орон нутгийн нөөц, боломжид тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх



5. Хөрөнгө оруулагч, хандивлагч нартай холбоо тогтоож, хөрөнгийн эх үүсвэр бий болгох.

Төлөвлөгөөнд сумын хөгжлийн алсын хараа, зорилго зорилтууд тэдгээрийн чиглэсэнүйл ажиллагаа, хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөр, төслүүдийгнэг бүрчлэн тодорхойллоо.

1.2. Зохион байгуулалт ба зохицуулалтын арга хэмжээ

1.2.1 Төлөвлөлт хяналтын хороо:

Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад зохион байгуулалтын хувьд баримталсан хандлагань сумын Засаг даргын Тамгын газар, бизнесийн ба мэргэжлийн бүлгээр төлөөлүүлэн олон нийт, оролцогч талуудыг зохион байгуулалтайгаар шууд оролцуулах боломжийг хангахад чиглэсэн юм. Сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээтэй холбогдсон арга хэмжээг хариуцсан бие даасан төлөвлөлт, хяналтын хорооны бүтцийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор, ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар ажиллуулах замаар иргэдийн оролцоог үндсэнд нь хангалаа.

Төлөвлөгөө боловсруулах үйл явц:



Төлөвлөлт, хяналтын хорооны гишүүд төлөвлөгөө боловсруулах ажлын үеэр



Төлөвлөлт, хяналтын хорооны бүдүүвч



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн: Дарга: А. Хоньрат –ЗДТГ-ын дарга

Гишүүд:

- Х. Талгат -МЭҮТ-ийн дарга
- Е.Пернегүл- ЖДҮ хариуцсан мэргэжилтэн
- Д. Алматы -Сумын нийгмийн ажилтан
- А. Кенжегүл -Архив, бичиг хэргийн эрхлэгч
- Б. Есерхан -Байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Н. Саттигүл – ХАА-ын мэргэжилтэн

ТӨЛӨВЛӨЛТ,ХЯНАЛТЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

1. Дарга - Ж.Сламбол /Сумын Засаг дарга/
2. Нарийн бичгийн дарга - Т.Акей /ИТХ-ын нарийн бичгийн дарга/ Гишүүд:
3. Ж.Тилеген - /Сумын Засаг даргын орлогч/
4. А.Өсермурат - Төрийн сангийн төлөөлөгч/
5. Шохан - /Татварын байцаагч/
6. Х.Талгат-/МЭҮТ-ийн эрхлэгч/
7. Б.Есерхан - /БОХ-ын байцаагч/
8. Д.Алматы - /Нийгмийн бодлогын түшмэл/
9. Д.Тунгат - /Газрын даамал/
10. Т.Альхан - /Бүрэн дунд сургуулийн захирал/
11. У.Холганат - /Ойгор сургуулийн захирал/
12. Ш.Молданияз - /Хөх хөтөл сургуулийн захирал/
13. З.Мухтар-/ХИЭС-ын эрхлэгч/
14. С.Айгүл - /Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч/



15. С.Күлшаш - /"Балбебек" цэцэрлэгийн эрхлэгч/
16. С.Алия - /Хөх хөтөл цэцэрлэгийн эрхлэгч/
17. Т.Ахылбек - /Соёлын төвийн хөгжмийн багш/
18. Ө.Майгул -/УЦУОШ-ний ажилтан
19. С.Еркежан -/7 дугаар багийн Засаг дарга/
20. Х.Хурметбек - /8 дугаар багийн Засаг даргша/
21. К.Багдаулет- /6 дугаар багийн Засаг дарга/
22. Ж.Болатбек/Бизнесмен/
23. М.Махсат - /Бизнесмен
24. М.Самурат - /5 дугаар багийн Засаг дарга/
- 26.О.Серикболат - /1 дүгээр багийн Засаг дарга/
27. Ш.Тилеген - /2 дугаар багийн Засаг дарга/
28. Т.Хайрол - /3 дугаар багийн Засаг дарга/
29. Т. Асылбек - /4 дүгээр багийн Засаг дарга/
- 30.С.Аманжол - /Арулар холбооны тэргүүн/
- 31.Х.Берденбек - /Залуучуудын холбооны тэргүүн/
32. Ш.Болатхан - /"Билүү бэлчээр" ТББ-ын тэргүүн

1. Бизнес орчны хөгжлийн ажлын хэсэг:

1. Ж. Тилеген- ЗД-ын орлогч
2. Ж. Болатбек- “Байкен” ХХК-ны захирал
3. Ш. Болатхан- Билүү бэлчээр” ТББ-ын тэргүүн
4. М. Махсат- бизнесмен
5. З. Шохан – татварын байцаагч
6. С. Аманжол – Арулар холбооны тэргүүн

3. Төр, нийгмийн үйлчилгээний хөгжлийн ажлын хэсэг

1. А. Хонырат- Тамгын газрын дарга
2. Д. Алмата- НБ-ын ажилтан
3. Т. Альхан- Бүрэн дун сургуулийн захирал
4. У. Холганат – Ойгор бүрэн бус дунд сургуулийн захирал
5. С. Айгүл – сумын төвийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
6. Ж. Молданияз – Хөххөтөл бүрэн бус дунд сургуулийн захирал
7. С. Күлшаш- “Балбөбек” хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
8. С. Алия –Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
9. З. Мухтар- сумын ЭМТ-ийн эрхлэгч
10. Т. Ахылбек – Соёлын төвийн эрхлэгч

3. ХАА, эдийн засгийн хөгжлийн ажлын бүлэг

1. Х. Талгат- МЭҮ-ийн тасгийн дарга
2. М. Саймурат – 5-р багийн Засаг дарга
3. А. Өсермурат – Төрийн сангийн төлөөлөгч
4. К. Багдаулет -6-р багийн Засаг дарга
5. Х. Хурметбек- 8-р багийн засаг дарга
6. Х. Берденбек- Залуучуудын холбооны тэргүүн
7. Т. Асылбек- 4-р багийн Засаг дарга



8. Т. Хайрол- 3-р багийн Засаг дарга


4. Байгаль орчны хөгжлийн ажлын бүлэг

1. Б. Есерхан- БОХ-ын улсын байцаагч
2. О. Серикмурат- 1-р багийн Засаг дарга
3. Ш. Тилеген- 2-р багийн Засаг дарга
4. С. Еркежан- 7-р багийн Засаг дарга
5. Д. Тунгат- газрын даамал
6. Ө. Мйгүл- УЦУШ-ний ажилтан

Хоёрдугаар бүлэг: СУМЫН ХӨГЖЛИЙН ОРЧНЫ ОДООГИЙН БАЙДАЛ

2.1. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын танилцуулга

2.1.1. Байгуулагдсан түүх



1921 оны Ардын хувьсгалаас өмнө Ховдын хязгаарт Шеруши, Шыбарайгыр гэсэн казахуудын хоёр хошуу Манж Чин улсын харьяалалд байв. Хувьсгалын дараах Монгол Улсын Засгийн газраас Х.Магсаржав тэргүүтэй албаны хүмүүс томилогдон 1922 оны 12 дугаар сард Шеруши хошууны ард иргэдийн хурлыг одоогийн Улаанхус сумын төвд хийлгэж, Шеруши хошууны захирагчаар С.Далелханыг сонгожээ.

1922 оны сүүлээр Шеруши хошууны төв Ахбалшыхт (одоогийн Улаанхус сумын төв)гаалийн газар байгуулагдан дотоод, гадаад худалдаанд хяналт тавихын хамт ард олны доторх иргэний асуудлыг шийдвэрлэдэг байжээ. 1923 онд энд ноос угаалгын газар байгуулагдсан.

300 гаруй хүн ажилладаг байв. 1923 оны хүн амын тооллогоор Шеруши хошууны 8 зангид 720 өрх харьяалагдаж байлаа. 1926 онд Шеруши хошууны даргыг ардчилсан журмаар сонгох анхны ардын хурал болж, хошууны даргаар М.Хойшы орлогчоор Х.Баймеш, нарийн бичгийн даргаар Т.Даутбай нар сонгогдсон байна. 1928 оны 12 дугаар сард хуралдсан Улсын 5-р Их хуралд тус хошуунаас С.Далелхан төлөөлөгчөөр оролцон, улмаар улсын бага хурлын гишүүнээр сонгогджээ. 1928 онд Ахбалшыхт казахын анхны бага сургууль байгуулагдан, 25 хүүхэдтэй эхэлж, анхны багшаар К.Баймухамед молла ажиллан, бичиг үсэг зааж байснаа, дараа нь тыва үндэстэн Т.Дүгэрэг багшилж, казах, монгол бичиг заадаг болжээ. Тухайн үед Казахуудын дотор бичиг үсэг мэддэг монгол хэлтэй шинэ засгийн бодлогыг мэддэг хүн цөөн байснаас 1931 оныг хүртэл тэр засгийн



бодлого олон түмэнд олигтой хүрдэггүй байжээ. Тиймээс Монголын нам, төрийн байгууллагаа Коминтерний шугамаар Казахстанас А.Хасымов, Ш.Өтепов нарын урьж ирүүлэн ажиллуулжээ. Тэдний оролцоотойгоор 1930 оны 6-р сард казахуудын дунд анхны улс төрийн байгууллага болон МАХН-ын үүр 22 гишүүнтэйгээр Шеруши хошуунд байгуулагдан, Намын үүрийн даргаар К.Оспан сонгогджээ. Энэ намын үүр тэр жилийн 10-р сард “Намын товчлох хороо” нэртэй өргөтгөгдөн байгуулагдсан байна.

Т.Дауитбай (1924 онд Улсын анхдугаар Их Хурлаас), С.Далелхан (1929 онд Монгол Улсын V Их Хурлаас), Ж.Мухан (1930 онд Монгол Улсын VI Их Хурлаас), Т.Турды (1934 онд

Монгол Улсын VII Их Хурлаас), О.Жамила (1938 онд VIII Их Хурлаас Бага Хурлын Тэргүүлэгч гишүүнээр), Б.Хаби (1938 онд VIII Их Хурлаас), М.Зайсанов (1938 онд VIII Их Хурлаас), М.Тохтамыс (1938 онд VIII Их Хурлаас).

Улсын Их хурлын депутатаар сонгогдсон хүмүүс:

Ш.Оразбай (1951 онд УИХ-ын анхдугаар сонгуулиар Ойгор сумаас), Т.Риян (1951 онд УИХ-ын анхдугаар сонгуулиар Улаанхус сумаас), Б.Хурметбек (1961 онд УИХ-ын анхдугаар сонгуулиар Толбо сумаас), М.Заухан (1954 онд УИХ-ын сонгуулиар Ойгор сумаас), Л.Ахбепи (1957 онд УИХ-ын сонгуулиар Улаанхус сумаас), Б.Шөрке (1963 онд УИХ-ын сонгуулиар Улаанхус сумаас), С.Сүлеймен (1966-онд УИХ-ын сонгуулиар Өлгий хотоос), Х.Ныгмет (1977 онд АИХ-д депутатаар), О.Болысбай (1986 оны АИХ-д депутатаар), А.Сарай (1990 оны АИХ-ын депутатаар), Х.Болодя (1992 оны УИХ-ын гишүүнээр).

Аймгийн даргаар ажиллаж байсан хүмүүс:

1. Баби Хаби /1940-1942 онууд/
2. Дүзелбай Женисхан /1943-1950 онууд/
3. Асханбайн Сарай /1970-1978 онууд
4. Жуанганы Рым /1959-1970 онууд/
5. Хузыкейн Дәрмен 2012 оноос

Эрдэмтэд: Ө.Хамбар, А.Минис, А.Нота, К.Бихумар, О.Шерхан, С.Жардембек, Р.Асай, Б.Хурметбек

Монгол Улсын Ардын цолтон: Ж.Хибатдолда.

Гавьяат цолтон: С.Шолтай, Ү.Ахтышхан, Б.Хурметбек, Ж.Хаду, Х.Сураган, Т.Мухамади, Х.Ахметбек.

Төрийн соёрхолт: А.Нота

Сүхбаатарын одонгоор шагнагдсан хүмүүс:

Н.Ардабай, А.Паней, Д.Ысхах, Т.Мухамади, Ж.Жүнисхан, Б.Хурметбек.

Мөн Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 20 хүн. “Алтан гадаас” 60 гаруй хүн шагнагджээ.

Улсын аварга, сайн малчнаар шалгарсан хүмүүс:

Улсын аварга малчинч: К.Оспан, О.Илияс, Ж.Орманбет, Н.Жанат, М.Абилмажим, А.Ахбапи, О.Болысбай, С.Бапаях, Б.Ханат, С.Гылымхан, У.Набет, Б.Сайболат, Ж.Шалатай, Ж. Берикбол

Улсын аварга тариаланч, хадланч: Б. Байтей, М.Жангабыл.

Аймгийн аварга, сайн малчнаар 40 гаруй хүн шалгарчээ. Улсын начин Т.Нурхадыл, Аймгийн арслан цол хүртсэн бөхчүүд: А.Паней, А.Түгелбай, М.Борбан, М.Азькей, М.Нажхей, З. Бохай, Ж.Алькей, С.Бердьхан, Б. Серик Зохиолч, яруу найрагчид: Х.Мэхфуз, Б. Иманшхан, И.Еликбай. Ж.Байыт, Х.Даян, П.Мурат, Б.Хызай, Ы.Беримбай, Ы.Кенес, С.Хабдай, Б.Марат.

Хөгжмийн зохиолч, хөгжимчин, нэртэй домборчид: Х.Файаолла, Б.Хибатдолда, А.Ахметбек, Х.Сахай, С.Өсерхан, Ф.Бержан, С.Хурмет.

2.1.1. Ус, усны амьтан, газрын гадарга, цаг уур

Баян-Өлгий аймгийн Улаанхус сум бол Монгол улсын хамгийн хүн ам ихтэй сумдын нэгэнд зүй ёсоор ордог. 7640 гаруй хүн амтай. Нэг сонирхолтой нь сумын нутаг дэвсгэрт



казахуудаас өөр нэг ч үндэстэн ястан амьдардаггүй ба ОХУ, БНХАУ- тай хил залгаа 2 сумын нэг юм. Монгол улсын хамгийн өндөр цэг болох Таван Богдын оргил энэ сумын нутагт оршдог. Одоогийн Улаанхус сум 1962 онд Ойгор сумыг тус суманд нэгтгэсний үр дүнд өргөжин бий болсон юм. Сумын өргөн уужим нутагт сургууль, хүүхдийн цэцэрлэг, хүний эмнэлэг тус бүр 3 бий. Тус сумын нутагт Монголд төдийгүй дэлхийд хосгүй, Ойгорын эртний сүг хадны бичээс нь 20 км талбайг эзэлж, эрдэмтэд болон жуулчдын анхаарал сонирхлыг татсаар байна.

2.1.2. Байгалийн баялаг, түүх дурсгалын болон үзэсгэлэнт газрууд

АЛТАЙ ТАВАНБОГДЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР



Монгол орны уул нурууд эмх замбраагүй тогтсон бус харин ч тодорхой чиглэлтэй бөгөөд тэр чиглэл нь нутгийн баруун зүүн хагаст харилцан адилгүй юм. Уулсын тогтолцоо болон уулс хоорондын хотгорууд нутгийн баруун хагаст баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон бол зүүн хагаст баруун урдаас ба зүүн хойш эргэж нийт уулын цуваа нум мэт цүлхийж тогтжээ. Нийт нутаг дэвсгэрийн эзлэх талбай 1566.5 мян км. АТББЦГ азар нь хойт талаараа ОХУ, баруун талаараа Таван богдоос баруун урагш Өвчүү уул хүртэл

БНХАУ – тай хиллэдэг бөгөөд уртаашаа 186 км, өргөөшөө 42 км газар нутгийг хамардаг .

Талбай нь бараг бүхэлдээ өргөгдсөн гадаргатай , далайн түвшнээс дээш 1800 – 4374 м, хамгийн өндөр цэг нь Монгол Алтайн нурууны ноён оргил Хүйтэн, хамгийн нам цэг нь Хурган нуур 1800 м, бүх нутаг дэвсгэрийн 80.0 % нь 1850 метрээс дээш өндөрт өргөгдсөн ба ерөнхийдөө 2400 – 2700 м байдаг . Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Судалгаанаас үзвэл 100 жилийн 50 – д нь уулын хээрийн бүсэд 100.0 – 125.0 мм хур тунадас унах магадлалтай ба өөрөөр хэлбэл хуурайвтар цөл, говийн нөлөөнд ихээхэн автагдсан өндөр уулын өвөрмөц уур амьсгалтай, маш эмзэг экосистем юм. АТББЦГ газар нь газрын гадаргын болон газар доорхи

усаар баялаг . Хотон, Хурган, Даян зэрэг мөстлөгийн гаралтай томоохон нууруудаас гадна 250 гаруй жижиг нуур, цөөрөм бий. Том нуурууд нь цэнгэг, хүйтэн устай нуурууд юм. Тиймээс хавар, зуны улиралд ус, намгийн олон зүйлийн шувууд нүүдэллэн ирж зусаж, үүрээ засан өндөглөдөг чухал газруудын нэг билээ. Өндөр уулын мөнх цас , мөсөн гол, ян сарьдаг, уулын нуга, хээрийн ландшафт, экосистемийн онцлогийг төлөөлсөн үзэсгэлэнт байгальтай, аргаль, янгир, халиун буга, зэрэг хөхтөн амьтан, ирвэс, хүрэн баавгай, хойлог, тас, ёл зэрэг жигүүртний гол байршил болдоогоороо зайлшгүй хамгаалах шаардлагатай нутаг юм.


ПОТОНИНЫ МӨСӨН ГОЛ



Монгол Алтай нурууны Таван богд уулсад манай оронд хамгийн томд тооцогдох Потанин, Александр, Гранегийн мөсөн голууд бий. Потанин мөсөн голын талбай 53.5 ам км юм./ Н.Дашдэлэг 1983/ Аялал жуулчлал нь дэлхий нийтийн хэмжээнд тасралтгүй өсөн нэмэгдэж буй үйлдвэлэл бөгөөд хүмүүсийн хувиараа аялах сонирхол ихээхэн нэмэгдэж, тэдний хувьд

нутгийн уугуул иргэдийн ахуй амьдралтай бодит байдалд нь танилцах сонирхол давамгайлж байгаа нь Монгол шиг нүүдэлчний уламжлалт зан заншлаа хадгалж чадсан орны хувьд гол үзмэр нь болж байгаа.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН НУТАГ БАГА ОЙГОРЫН ЦАГААН САЛААГИЙН ХАДНЫ СҮГ ЗУРАГ



Цагаан салаагийн хадны сүг зураг нь уулын өвөр биед байрласан хавтгай гөлгөр чулуун дээр зурагдсан бөгөөд хэсэг хэсгээрээ бөөгнөрөн байрласан байдаг. Уртаараа 15 км орчим зайд үргэлжилнэ. Эрдэмтдийн үзэж байгаагаар 10000 орчим зургаас бүрддэг байна. Зургийн гол сэдэв нь мал аж ахуй, ан агнуур юм. Мөн тэр үеийн ан амьтдыг урнаар дүрслэн үлдээсэн байдаг. Ан агнуурын тэр үеийн арга барил, зэрлэг амьтдын ааш араншингийн талаар маш

дэлгрэнгүй тод томруун дүрсэлсэн нь тоогоороо утга санаагаараа хосгүй зүйл гэж тооцогддог. Хадан дээр зурж үлдээсэн урлагийн энэ бүтээлүүдийг харьцуулах өөр бүтээл байхгүй. Төв Азийн болон бусад орнуудад тохиолддог боловч тоо хэмжээгээрээ, зургийн уран сайхны илэрхийллээрээ Бага Ойгорын хадны зураг илүү гэдгийг судлаачид тогтоосон байдаг.

Энэ бол үнэхээр гайхамшиг.

СИЙЛХЭМИЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

"А" хэсэг



Сийлхэмийн нурууны байгалийн цогцолборт газар Баян-Өлгий аймагийн Улаанхус сумын нутагт улсын хил дагуу 14080 га талбай бүхий А"Б хоёр хэсгээс бүрдсэн газар нутгийг Улсын их хурлын 2000 оны 29 дүгээр тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан

Сийлхэмийн нурууны А хэсэг: Хар ямаатын эх хар Чулуут,

Шар ямаат, Шар нохойт уул, Бор бургас голын эх, багтана. Сийлхэмийн нурууны А хэсгийн Хар ямаатын голын хөндийн МЭӨ 3-2 зуунд амараах хиригсүүр, хөшөө МЭӨ 6-8 дугаар зууны амараах хүн хөшөө, чулуун зэвсэгийн дурасгал, хадны сүг зургаар У-сай дах эртний Монгол, Турк аймагийн булш, хүрэл зэвсэгийн үсийн хадны зураг бичгээр нь Монголд төдийгүй төв Азийн ард түмний ан агнуур нүүдлийн мал аж ахуй, тэдний соёл түүхийг судлахад чухал ач холбогдолтой зэрэг онцлогийг харгалзан улсын тусгай хамгаалалтанд авсан.

Энд дэлхийн болон Монголд ховордсон Ирвэс, Алтайн аргаль угалз, Янгар, манууль, шувуудаас ёл, тас, цармын бүргэд, алтайн хойлог, Сэвдэгийн цагаан ятуу, цагаан чонхор, гол горхинд алтай нугас, монгол хадран, загас элбэг байдаг. Ховор ургамлаас вансэмбэрүү, алтангагнуур, сөд өвс, алтай сонгино, монгол доогор, жимснээс тоошлоо, хад элбэг тархасан.



Ан амьтан: Улаанхус сумын нутагт нэн ховордсон болон ховордсон ан амьтан ихээр амьдардаг

Өндөр ууланд янгир, аргаль, ирвэс, хүрэн баавгай, г.м ан амьтан элбэг байдаг.



Ашигт малтмал:

Манай сумын нутаг нь геологийн тогтцын хувьд нутгийн ихэнх хэсгээр уул хад хайрга, элсэнцэр, шавранцар, хурдас түгээмэл тархсан бөгөөд Ховд, Ойгор голын хөндийгөөр ихээхэн байдаг. Сийлхэмийн нуурын өмнөд захаар уулын бялхмаг чулуулаг, У сайд гянтболд, Хүрэн хайрхан уул орчмоор эртний төрмөлийн гүний гаралтай чулуулаг элбэгтэй. Баянзүрх уулын зүүн талаархи нутагт чулуу тархмал байдаг. Манай сумын нутаг хэвлийдээ болон хөрсөн дээрээ өнгөт металл ба металл бус ашигт малтмалын багагүй баялагтай. Тухайлбал: Брбургаст алтны Усайд хүдэр, Билүүгийн аманд мөнгөн ус, хар тугалаг, Улаантолгой, Хөндийн ууланд чулуун нүүрсний илэрцүүд ажиглагддаг ба цагаа, хужир, наанги шороо, гялтгануур, боржин чулуу, зос элбэг бий. Ашигт малтмалын хувьд судлагдан шинжлэгдсэн тодорхой нөөцтэй илэрцүүдтэй боловч эдийн засгийн эргэлтэнд оруулж, ашиглахгүй байгаа нь сүүлийн жилүүдэд уул уурхайн чиглэлээр ашиглалтын болон хайгуулын зөвшөөрлийн эрхийг олгоогүйтэй холбоотой бөгөөд байгалиа унаган төрхөөр нь хадгалах боломж бүрдсэн болно.

Цаг агаарын нөхцөл байдал: Сумын нутаг нь бүхэлдээ уулархаг бүсэд багтдаг. Эрс тэс хуурай уур амьсгалтай. Зундаа гандуу, өвөлдөө хахир хатуу хүйтэн болдог, хавар, намар салхи шуурганы давтамж ойр ойрхон байдаг онцлогтой нутаг юмаа. Газар зүйн бүсийн хувьд Монгол Алтайн нуурууд оршдог учир агаарын уруудах урсгал зонхилж эсрэг циклон үүсэн тогтвортой байрладаг. Өвлийн улиралд эсрэг циклон тогтвортой байрласнаар цаг агаар тогтуун салхигүй болж, шөнөдөө ихээхэн хүйтэрдэг учир тус суманд жилд дунджаар 90-110 хоног хүйтэн хадгалагдаж байдаг. Харин дулааны улиралд их хэмжээгээр халж жил бүрийн 6-8-р сард халуун хадгалагддаг. Өвөл, хаврын улирал үргэлжлэх хугацаа харьцангуй урт, зуны улиралд хур тундас бага унадаг учраас ерөнхийдөө хуурай уур амьсгалтай. Жилд орох хур тундасны хэмжээ дунджаар 33.1-87.4 мм байх бөгөөд дийлэнх нь 7,8,12-р сард ордог. Тус сумын нутагт цас харьцангуй бага орох бөгөөд өвлийн улиралд хүйтэн жиндүү



байх хугацаа урт байдаг учраас цасан бүрхүүлтэй хоногийн тоо жилд дунджаар 70.4 хоног байна. 3-11 сарыг хүртэл хугацаанд салхи шуурганы давтамж ихсэж 15 м/с –ээс дээш салхи шуургатай хоног жилд дунджаар 45-60 хоног байна. Жилийн дундаж хамгийн хүйтэн нь -22⁰ С, хамгийн дулаан нь сарын дундаж 20⁰ С байдаг.

Гадаргын болон гүний үсны нөөц: Нутаг дэвсгэрийн 1\3-ийг ус

эзэлдэг. Монгол оронд усны нөөцөөр 2-т ордог Хар нуур, Даян нуур, Ховд, Ойгор голуудтай.

Ховд гол: Алтай нурууны ноён оргил Алтайн таван богд уулнаас эх авч баруун хойд зүг Цэнгэл сумын нутгийг дамжин 208 км урсаар манай сумын нутагт орж ирж 62 км урсаж Сагсай сум, аймгийн төвийг дайран урсдаг ба Ховд аймгийн Хар ус нуурт цутгадаг. Сав газрын талбай ам км, хэвгий 2,3 хувь болно. Сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын өөрчлөлт, хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас хамааран Ховд голын ус татарч ширгэх, улмаар 2 нуурын усны түвшин багч, салаа голуудын голидрол алдагдаж элсэн хэв үүсэх, загас жараахай ихээр устаж үгүй болох аюул нүүрлээд байна.

Эртний түүх соёлын дурсгал:

1928 онд баригдсан анхны сургуулийн хичээлийн байр



Нутгийн удирдлагын зохион байгуулалт

2.2.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Монгол Улсын шинэ ардчилсан үндсэн хууль батлагдсанаар 1992 онд тус сумын



Иргэдийн
Төлөөлөгчдийн
Хурал байгуулагдаж
тухайн нутаг
дэвсгэрийнхээ ойрын
болон хэтийн эдийн
засаг, нийгэм, соёлын
хөгжлийн бодлого
чиглэлийг улс,
аймгийн бодлого
шийдвэр, орон
нутгийн иргэдийн
ашиг сонирхолтой
уялдуулан
тодорхойлж,
шийдвэр гарган
түүнийхээ


хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. Тус сумын ИТХ нь төлөөллийн зарчмыг хангасан тухайн нутгийн иргэдийн өөрсдөө сонгож байгуулдаг Үндсэн хуулийн статустай Нутгийн Өөрөө Удирдах байгууллага юм.

Сумын ИТХ-ын эрхэм зорилго нь: Ардчиллыг бэхжүүлж, НӨУЁсыг төлөвшүүлэх, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэх, нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй, хөгжлийг хангах явдал юм.

Сумын ИТХ-ын удирдлагын талаарх мэдээлэл: 1992-1996 онд ИТХ-ын анхны орон тооны бус даргаар Р. Хажим, 1996-2000 онд орон тооны даргаар Х. Аманкелди, 2004-2008 онд Ж. Сламбол, 2008-2012 онд Ж. Баатаржав, 2012 оноос Н. Айдолда сонгогдон ажиллаж байна.

БАЯН ӨЛГИЙ аймгийн УЛААНХУС сум 2012 онд батлагдсан Монгол улсын ЗЗНДНТУ-ын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ өөрчлөлтөөр 2012 оны сумын ИТХ-ыг сонгох 6 дахь удаагийн сонгуулиар 27 төлөөлөгч сонгогдосон байна. Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Х. Болат, К. Онаншбай, М. Навихан, Н. Айдолда, Ш. Бодаубай нар ажиллаж байсан бөгөөд 2011 оноос одоог хүртэл Т. Акей ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Хурал нь нутаг дэвсгэртээ хууль эрх зүйн хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох, орон нутгийн хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчноо хамгаалах, хүний нөөцийн талаар тодорхойлогч чиглүүлэгч байж, ядуурлыг бууруулах, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, иргэдийн нийгмийн асуудал зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд орон нутгийн нөөц боломж онцлогийг тусган бодлого боловсруулж хэрэгжүүлэгч байх зорилтыг өмнөө тавин ажиллаж байна.

Схемээр үзүүлбэл:



7-р
багийн ИНХ

8-р
багийн ИНХ

Сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан хүмүүс

№	Ажилласан жил	ИТХ-ын дарга	Нарийн бичгийн дарга
1	1992-1996	Р. Хажим	Х. Болат
2	1996- 2000	Х. Аманкелди	М. Навихан
3	2000-2004	Р. Төкей	Н. Айдолда
4	2004-2008	Ж. Сламбол	Ш. Бодаубай
5	2008 -2012	Ж. Баатаржав	Т. Акей
6	2012- оноос	Н. Айдолда	Т. Акей

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Үндсэн хуулийн статустай • Ажиллах нөхцөл бүрдсэн өрөө танхимтай • Мэргэшсэн цомхон бүтэцтэй. 	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын төсвийн хүрэлцээ муу • ИТХ-ын төлөөлөгчдийн мэдлэг чадвар харилцан адилгүй • ИТХ-ын төлөөлөгчдийг ажиллуулах эдийн засгийн хөшүүрэг байхгүй
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн төсөв, татварын орлогыг зохицуулах • Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх • Байгалийн баялагаа ашиглан эдийн засгийн хөгжлийг тодорхойлох 	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн иргэдийн шилжилт хөдөлгөөн их, хүн амын сууршил муу • Байгууллагын төсвийн хүрэлцээ муу тул иргэдэд төдийлөн сайн хүрч ажиллаж чаддаггүй • Өөрийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан хуралдааны танхимгүй

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
ИТХ-ын төлөөлөгчдийг чадвар, мэдлэг боловсролын дутмаг байдал	Сургалт мэдээллийг олон хэлбэрээр зохион байгуулах Туршлага судлах
Төлөөлөгчдийн нийгмийн асуудал, ажиллах нөхцөл боломж дутмаг	Санал боловсруулж хүргүүлэх замаар ИХТөлөөлөгч, ИНХ-ын ажиллах нөхцөл

	боломж урамшууллын механизмыг бий болгох Төсөл хөтөлбөрт хамрагдах, хандивлагч татах замаар ажиллах орон байр, техник хэрэгслээр хангах
Төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдал ИНХ-ын дарга нарын ажиллах нөхцөл болом	Орон нутаг, улсын төсөв, төсөл хөтөлбөрүүдийг зөвзохистой зарцуулах, хэрэгжүүлэх

2.2.2. Нутгийн захиргаа



Монгол Улсын шинэ үндсэн хууль ЗЗНДНТУТ хууль Засгийн Газрын 1992 оны 24-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1992 оны 10-р сарын 1-нд сумын Ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргааны бүтэц зохион байгуулалт, агуулгыг өөрчилж сумын Засаг даргын Тамгын газар болон өөрчлөгдсөнөөс хойш төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Өглөөнөөс үдэш хүртэл хүн зоны хөл үл тасрах газрын нэгэн бол сумын Тамгын газар. Алба амины ажлаа

амжуулах, сумын удирдлагуудтай уулзаж санаа бодлоо хуваалцах, гэр бүл үр хүүхдээ бүртгүүлэх, татвар хураамжаа төлөх, гэр бүл үр хүүхдээ бүртгүүлэх гэсэн олон зуун иргэдийн их хөлийн газар. Эхээс мэндлэхээс эхлээд насан хутгийг олох хүртэл хүмүүс төрийн үйлчилгээг хүртэж, төрөө дээдэлж явдаг жамтай ажгуу. Ийнхүү хүмүүн заяанд төрсөн олон түмэндээ төрийн үйлчилгээг хүргэж төрийн бодлого шийдвэрээ таниулж төрийнхөө хайр ивээлд авч зарим нэгэн дэгтүйд нь төрийн төмөр нударга үзүүлэх гэх мэт энэхүү хариуцлагатай нэр хүндтэй үүрэг ачааг үүрч яваа хүмүүс бол Засаг даргын Тамгын газрын хамт олон.

Засаг даргын Тамгын газар нь удирдах-3, гүйцэтгэх -8, үйлчилгээний -2, гэрээт-5, мөн цагдаагийн алба, нийгмийн даатгал, хөдөлмөр халамж үйлчилгээ, татварын алба гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

1992 оноос хойших сумын удирдлагууд :

№	Ажилласан жил	Засаг дарга	Орлогч дарга	Тамгын газрын дарга
1	1992-1996	Р. Хажим	З. Тохай	Н. Айдолда
2	1996- 2000	Ө. Мельс	З. Тохай	Н. Айдолда
3	2000-2004	Х. Болат	Р. Атимхан	К. Онашбай
4	2004-2008	Х. Болат	Б. Муса	К. Онашбай
5	2008 -2012	Т. Ташкен	Б. Муса	А. Хоньрат
6	2012- оноос	Ж. Сламбол	Ж. Тилеген	А. Хоньрат


ЗДТГазрын SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • ИТХ болон төрийн байгууллагууд ААН-тэй хамтын ажиллагаа сайн • Боловсон хүчнээр хангагдсан • Тоног төхөөрөмж хүрэлцээтэй • Төсөв санхүү хүрэлцээтэй • Орон нутгийн орлого сайн • Мэргэжилтэнүүдийн мэргэжлийн ур чадвар сайн 	<ul style="list-style-type: none"> • Өрөө тасалгааны тохижилт муу • Интернет болон дотоод сүлжээнд холбогдоогүй • Тамгын газрын барилга муудсан
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Мэргэжилтэнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах • Нэг цэгийн үйлчилгээ бий болгох • Шинэ барилгатай болох 	<ul style="list-style-type: none"> тул төсвийн зардал хэтрэх магадлалтай • Орон тоо цөөн • Хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэх

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Нутгийн захиргааны ордон бариулах	Санал хүсэлтээ уламжилж улсын төсөвт суулгах
Ажилчдын нийгмийн асуудалд анхаарах, мэдлэг боловсрол доогуур	Сургалтын олон хэлбэрээр сургаж мэргэшүүлэх Туршлага судлуулах
Ажиллах нөхцөл боломж, ажлыг байрны тав тух хангалтгүй	Засвар хийх, байр өрөө нэмэгдүүлэх, багийн төвүүдийг ашиглалтанд оруулах зэргээр орчин бүрдүүлэх
Орчин үеийн техник хэрэгсэл дутмаг	Төсөл хөтөлбөрт хамрагдах, төсөв нэмэгдүүлэх, хандивлагч татах зэргээр санхүүгийн асуудлыг шийдвэрлэж техник хэрэгслээр хангах
Багийн төвүүдийн байнгын ажиллагаахангагдаагүй	Багийн төвүүдийг стандартын дагуу чанартай бариулах, Багийн Засаг дарга нар баг дээр ажиллах нөхцөл, техник хэрэгслээр хангах

Сумын Засаг даргын Тамгын газрыг бүтцийг бүдүүвчээр үзүүлбэл



Засаг захиргааны анхан шатны нэгж:

/ 2013 оны байдлаар/

№	Багийн нэр	Өрхийн тоо	Хүн ам	Малын тоо	Сумын төвөөс алслагдсан зай /км/
1	Их ойгор	214	1037	27021	110
2	Хөххөтөл	281	1379	27800	60
3	Хулжаа	172	769	16550	55
4	Согоог	212	981	12450	23
5	Баян зүрх	137	665	15777	34
6	Даян	191	943	35904	120
7	Билүү- 1	192	937	5751	Сумын төв
8	Билүү- 2	276	1187	16858	Сумын төв
	ДҮН	1669	7898	158201	

Их ойгор баг



Тус баг нь сумынхаа төвөөс баруун зүгт 110 км-т Жалпах хэмээх газарт багийн төв нь оршдог. Тус баг нь 104443 га газар нутагтай хойд талаараа ОХУ, Цэнгэл сумтай хил залгаа оршдог. Улсын *тахиалгат Алтайн таван богдт уул* энэ байгийн нутагт байдаг юм. 2013 оны жилийн эцсийн тооллогоор 215 өрхийн 1039 хүн ам 27053 толгой мал тоологдсон.

Хөххөтөл багийн танилцуулга

Хөххөтөл баг аймгийн төвөөс 100 км, сумаас 56 км алс оршдог газрын хэмжээ 81700 га төвлөрсөн

суурин баг. Бүрэн бус дунд сургууль, Их эмчийн салбар, Хүүхдийн цэцэрлэг, Төрийн банкны тооцооны төв үйл ажиллагаа явуулдаг ба төвлөрсөн цахилгаан эрчим хүчний шугамд холбогдсон.

2013 оны жилийн эцсийн тооллогоор 281 өрх, 1379 хүн, 28300 мал тоологдсон байна. Тус багт талх нарийн боовны үйлдвэр, барилгын материалын жижиг үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна.

Хулжаа багийн танилцуулга

Хулжаа баг ОХУ, Ногооннур сум болон Хөххөтөл, Баянзүрх, Согоог багуудтай хил залгаа оршдог ба газар нутгийн хэмжээ 74500 га. Сийлхэмийн нурууны тусгай хамгаалалттай газар нутгийн “А” бүсэд хамаардаг. Тус багт нэн ховордсон болон ховордсон ан амьтан ихтэй, аргаль, янгир голдуу амьдардаг. 2012 онд төвлөрсөн эрчим хүчний шугамд холбогдсон

Согоог багийн танилцуулга

Согоог багт 2013 оны жилийн эцсийн тооллогоор 215 өрх 1200 гаруй хүн амтай, 12450 толгой мал тоолуулсан. Сумын төвөөс 22 км оршдог. Тус багт Бүрэн бус дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, 10 гаруй худалдааны цэг 8 хоршоо үйл ажиллагаа явуулдаг. 2010 онд төвлөрсөн эрчим хүчний шугамд холбогдсон.

Баянзүрх багийн танилцуулга

Улаанхус сумын 5-р баг 1992 онд байгуулагдсан. Анхны Багийн Засаг даргаар 1992 оноос 1996 он хүртэл Байжигит овогтой Март сонгогдон ажилласан.

1996 оноос 1998 он хүртэл Багийн Засаг даргаар Ордахан овогтой Минат, Иргэдийн Нийтийн Хурлын даргаар Ардаханы Загив. 1998 оноос 2000 он хүртэл Багийн Засаг даргаар Хайрбереке овогтой Шайза, Иргэдийн Нийтийн Хурлын даргаар Ардаханы Загив, 2000 оноос 2012 он хүртэл Жаман овогтой Тилеген, 2000-2004 он хүртэл Иргэдийн Нийтийн Хурлын даргаар Малгажы овогтой Бердимурат, 2004-2012 он хүртэл Замзам овогтой Хурметхан нар тус-тус сонгогдон ажилласан. 2013 оны 1-р сараас 9-р сар хүртэл Багийн Засаг даргаар Ауелхан овогтой Хуантай, 2013 оны 9-р сараас Малгажы овогтой Самурат, ИНХ-ын даргаар Зайнскей овогтой Ахболат нар ажиллаж байна.

Багийн эмчээр 1992 оноос 2000 он хүртэл Зиядаиы Бохай, 2000 оноос одоо хүртэл Малгажы овогтой Бердимурат. Малын эмчээр Шонайн Нэгдэлхан нар ажиллаж байгаа. Тус багт 2013 оны эцсийн мал тооллогоор 15777 толгой мал тоолуулсан. 137 өрхтэй, 665 хүн амтай. Үүнээс эрэгтэй 326, эмэгтэй 339 байгаа.

Манай багаас Сум, Аймаг, Улсын хэмжээний тэргүүний алдартнууд олноор төрөн гарсан. АИХ-ын депудат С.Агат. Улсын Аварга малчид С.Балаяах, М.Авилмажим, Улсын Аварга анчин А.Загив. Улсын Залуу аварга малчин А.Хуанбай нар төрөн гарсан. Алтан гадас одонгоор С.Балаяах, М.Авилмажим нар шагнагдсан. Аймгийн Аварга малчин А.Өнерхан. анчинаар М.Авилмажим наршалгарч байсан. Багийн газар нутгийн хэмжээ 85900 га газартай

Даян багийн танилцуулга

Даян баг нь урьд талаараа БНХАУ, Сагсай сумтай, хойд талаараа Цэнгэл сумтай хийл залгаа оршдог. Газар нутгийн хэмжээ 98700 га. 2013 оны жилийн эцсийн тооллогоор 189 өрхөд 950 хүн амьдарч байна. Малын тоо .35942, газар нутгийн 3|1 нь тусгай хамгаалалттай газар нутагт багтаж байна.

Малчин өрхүүд хавар, зун, намар сумаас 120-150 км газар нүүдлэн амьдардаг ба малын тоогоор сумын 8 багаас хамгийн олон малтай багт ордог.

1992 оноос тусг багийн Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

Х. Алдамадия, Х. Мадениет, Ш. Болатхан, С. Даулетбек, К. Багдаулет

“Ахбалшык” багийн танилцуулга

“Ахбалшык” баг нь сумын төвд байрлдаг баг 2013 оны жилийн эцсийн тооллогоор 146 өрх 946 хүн тоологдсон. Газар нутгийн хэмжээ 20500 га малын тоо 5844 .

Көкадыр байгийн танилцуулга

Көкадыр баг нь сумын төвд байршилтай газар нутгийн хэмжээ 72700 га 2013 оны жилийн эцсийн тооллогоор 242 өрхөд 1008 хүн тоологдсон ба 16858 толгой мал тоолуулсан суурьшмал багуудын нэг юм.

Багуудын SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
<ul style="list-style-type: none"> • МАА түүний дотор тэмээн сүргийн түлхүү өсгөх боломжтой • Багийн дарга, эмч унаатай болсон • Багийн төвүүд шинээр баригдаж байна 	<ul style="list-style-type: none"> • Багийн иргэд хөдөлмөрөө хамтрах, хорших талаар ойлголт дутмаг • Иргэдийн боловсролын түвшин доогуур, аминч, бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй. • Багийн хөгжил сул. • Холбоо харилцааны сүлжээнд багийн бүх иргэд жилийн 4 улиралд хамрагдах боломж хязгаарлагдмал. • МАА-гаас өөр АА эрхлэх боломж хязгаарлагдмал
<i>Боломж</i>	<i>Саад бэрхиээл</i>
<ul style="list-style-type: none"> • Байгалийн үзэсгэлэнт газар, нуур голуудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх • Багийн төв шинээр баригдаж төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх боломж бүрдсэн. • МАА-н фермер, болон бусад ГТ, МАА-н чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Сумын төвөөс алслагдмал, гол устай, төрийн үйлчилгээг хүргэхэд өртөг өндөр. • Байгалийн эрсдэл, ган зуд

Улаанхус сумын одоогийн чадавхийн үнэлгээ

№	Үүргүүд	Үнэлгээ					Сумын дундаж
		1	2	3	4	5	
							5
1	Маркетинг	10	14	20	3	3	2,1
2	Хөрөнгө, оруулагчтай холбоо тогтоох	4	10	16	17	3	2,6
3	Орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоотой байх	1	12	20	14	3	2,6
4	Стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих	4	10	20	12	4	2,9

5	Урамшуулал бий болгох санхүүжилт олгох	8	10	23	5	4	2,7
6	Ажиллах хүчний хөгжил	5	10	24	8	3	3,7
7	Эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх хянах	6	10	24	7	3	2,4
8	ОНЭЗХ-н төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	5	15	22	4	4	2,3
9	Засаг дарга болон Иргэдийн хурлын зөвлөгөө мэдээллээр хангагдах түвшин	3	15	18	11	3	2,4
10	Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төв байгууллагатай харилцаа тогтоон ажиллах	8	15	20	4	3	2,2
11	Мэдээллийн сан байгуулах	7	20	16	6	1	2,1
12	Үйл ажиллагаагааг тайлагнах	4	10	17	14	5	2,6
13	Олон нийтийн харилцаа	5	10	20	11	4	2,5
ДҮН							2,5

Сумын чадавхийн үнэлгээг 100 иргэнээс авсан бөгөөд авсан үнэлгээнд дүгнэлт хийхэд үзүүлэлтболгон дээр тухайн үүрэг маш бага түвшинд хэрэгждэг гэсэн үнэлгээ өгчээ. Дээр дурдсан үнэлгээний үр дүнд хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа сумын удирдлагын чадавхийг сайжруулах асуудлуудыг тусгах шаардлага гарч байна.

2.1.3. Ахуй соёл, иргэншлийн онцлог


Тус сум нь казахүндэстэн зонхилсон иргэдтэй хувьсгалаас өмнө болон дараахь жилүүдэд казахуудын улс төр, захиргаа, соёлын төв болж байсан ба казах үндэстэнүүдийн төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэд, зохиолчид, гавъяатнуудын өлгий нутаг болсон.

Хүний нөөц, амьжиргааны чадавхи

2.1.4. Хүн амын үзүүлэлтүүдийн хандлагын судалгаа

	2009	2010	2011	2012	2013
Сумын нийт хүн ам	8407	7318	7641	7340	7898
Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагсад	3373	2961	2804	3079	3279
Ажиллагчид, үйлдвэрлэлийн салбараар					
Мал аж ахуй	1204	610	870	800	514
Газар тариалан	97	110	118	120	121
Цахилгаан дулаан	2	2	3	3	4
Холбоо, тээвэр	1	1	1	1	1
Худалдаа үйлчилгээ	45	60	71	87	91
Төрийн байгууллага	340	364	373	388	392
Боловсрол	120	160	167	175	180
Эрүүл мэнд	56	58	60	64	65
Бусад	6	8	9	9	9
Бүгд					
Хөдөлмөрийн насны хүн ам					

Дээд боловсролтой	380	456	457	459	487
Тусгай дунд боловсролтой	230	200	203	235	200
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	237	268	265	285	290
Мэргэжилгүй					
Ажилгүйчүүдийн тоо	28	38	55	32	31
Үүнээс: эмэгтэй	320	120	340	34	31
Ажилгүйдлийн түвшин, %					
Сумын өрхийн тоо					
Өрхийн амьжиргааны түвшний ангилал					
Чинээлэг					
Ядуу бус дунд					
Ядуу бус бага орлоготой					
Ядуу	1143	937	545	477	402
Нэн ядуу	646	491	203	202	198



Мал аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтүүдийн хандлага

Мал аж ахуйн салбар	2009	2010	2011	2012	2013
Малын нийт тоо	146170	124056	135770	144615	158278
Тэмээ	597	597	621	659	684
Адуу	5379	4459	4752	4843	5434
Үхэр	9030	7727	9028	9626	11614


Хонь	70027	58853	62024	67107	75213
Ямаа	61144	52420	59345	62280	65333

Эдийн засгийн үндсэн салбарууд

Сумын эдийн засгийн үндсэн салбар нь уламжлалт мал аж ахуй юм. Зах зээлийн нөхцөлд нэгдлийн өмчид байсан малыг малчид, хувийн жижиг үйлдвэрлэгчдийн мэдэлд шилжин очсоноор үйлчилгээний чиглэлийн жижиг бизнесменүүд төрүүлэх шинэ нөхцөл бүрдүүлсэн онцлогтой.


2.1.5. Мал аж ахуй

Тус сумын эдийн засгийн гол үндэс нь бэлчээрийн мал аж ахуйн салбар бөгөөд эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэнд гол байр суурь эзэлдэг. 2013 оны эцсийн байдлаар мал сүргийн



тоо 158200 толгойд хүрч сумын хэмжээнд малтай өрх үүнээс малчин өрх тооллогдсон нь малтай нэг өрхөд малтай өрхийн хүн ам тутамд толгой мал ноогдож, нийт ажиллагсадын 72.6 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж, сумын дотоодын нийт бүтээгдэхүүний 64.5 хувийг үйлдвэрлэж 26 байна. Мал аж ахуйн салбарт ажиллагчдын дотроос улсын сайн малчин 5, аймгийн сайн малчин 16, сайн малчин 100 гаруй тус тус төрөн гарчээ. Сүүлийн

жилүүдэд мал сүрэг тоо толгойн хувьд эрчимтэй өсч байгаа боловч сүргийн бүтэц алдагдажбод мал, хонин сүргийн эзлэх хувь багасан нийт малын 60 гаруй хувийг ямаа эзлэх болсноор бэлчээр талхлагдах, хүйтний улиралд малын хот хэвтэр хөлдөж, зутарснаас мал сүрэг олноор хорогдох зэрэг сөрөг нөлөөлөл ажиглагдаж байна.



Мал аж ахуйн свот шинжилгээ

Давуу тал	Сул тал
------------------	----------------

<ul style="list-style-type: none"> • Улсын МЭҮТасаг байгуулагдаж ажиллахнөхцөл, техник хэрэгсэл, унаа машинаархангагдсан • Халдварт өвчний гаралт харьцангуй тайван • Мал сүрэгт нэн тохиромжтой өвстэй, үхэрдээр төвлөрөн эрчимжсэнМАА хөгжүүлэхболомжтой • Малчдын бүлэг хоршоо байгуулагдсан 	<ul style="list-style-type: none"> • Малчдын мэдлэг боловсрол тааруу • МАА-н мэргэжилтэн дутагдалтай. • МАА-н бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрхөгжөөгүй • Сүргийн бүтэц алдагдсан • Малын чанар муудаж, ашиг шим буурсан • Мал эрүүлжүүлэх ажилүйлчилгээ тааруу • Малын даатгалын тогтолцоо төлөвшөөгүй • Бэлчээрийн даац хэтэрсэн • Мал сүрэг байгалийн эрсдэлд өртөмхий
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> • Төрөөс малчид, МАА-н салбарыг дэмжсэн хуульэрх зүйн орчин бүрдсэн “Монгол мал хөтөлбөр” • ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржбайгуулагдсан 	<ul style="list-style-type: none"> • Байгалийнгамшгийндавтамжойртсон • Гоцхалдвартөвчингарсантохиолдолд олонмалөвчлөхмагадлалтай • Бэлчээрийндоройтолнэмэгдэххандла гатай

Газар тариалан

	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013
Тариалсан талбай						
Төмс	Га	5,1	5,1	5,1	5,1	6,2
Хүнсний ногоо	Га	1,5	1,8	1,5	1,6	1,8
Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл						
Төмс	Тн	73,6	72,2	75,4	70,2	78,6
Хүнсний ногоо	Тн	16	17,5	18,2	19	17,5
Хадлан	Тн	2875	4120	4735	4300	5200,6

Газар тариалан

Улаанхус сум нь 1965 оноос эхлэн газар тариалан эрхлэж эхлэсэн 2,5-33,5 га-д төмс, хүнсний ногоо, малын тэжээл тариалжбайна. Тус сум сүүлийн 5 жилд 2 төсвийн байгууллага, 4 хоршоо, 1 нөхөрлөл, 143-172 өрх газартариалан эрхэлж, 1 га-аас төмс 160-260ц, байцаа 276-414ц, манжин 160-200ц, лууван 160-190ц,нарийн ногоо 150-200 ц-ийг тус тус хураан авч сумын нийт ХАА-н бүтээгдэхүүний үйлдэрлэлийн 25 хувь нь газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна. Мөн улиас, хайлаас, чацарганагэх мэт 8000-10000 модыг үрээр нь, суулгацаар тариалж суулгац бэлтгэж

байна.Тус сумынтариаланчид ажил үйлсээрээ шалгарч улсын тэргүүний тариаланч 3, аймгийн тэргүүний тариаланч6, сумын тэргүүний тариаланч 11 төрөн гарсан байна.

Газар тариалангийн салбарын SWOT

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
<ul style="list-style-type: none"> • Усалгаанд ашиглах усны нөөц хүрэлцээтэй • Иргэдийн ГТ-ийн аж ахуй эрхлэх сонирхол нэмэгдэж байгаа • Сумын иргэд орон нутгийн хүнсний ногоог хүнсэндээ хэрэглэх сонирхолтой • Газар тариаланд ашиглах газрын нөөцтэй 	<ul style="list-style-type: none"> • Үржил шимт хөрс тааруу • Газар тариалан эрхэлж байсан туршлага, технологи байхгүй • Мэргэжилтэй боловсон хүчин дутмаг • Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө гараагүй, энэ чиглэлийг тусгаагүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
<ul style="list-style-type: none"> • Энэ чиглэл хөгжөөгүй учир өрсөлдөгч байхгүй • Ховд гол дагуу Чацаргана болон бусад төрлийн тариалан эрхлэх боломжтой. • Төрийн бодлого энэ чиглэлийг түлхүү дэмжиж байгаа 	<ul style="list-style-type: none"> • Газар тариалангийн чиглэлийн техник хэрэгсэл дутагдалтай. • Энэ чиглэлийн төсөл хөтөлбөр хэрэгждэггүй. • Санхүүгийн боломж муу.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Энэ чиглэл хөгжөөгүй, техник тоног төхөөрөмж байхгүй.	Төсөл хөтөлбөрт хамрагдах, лизингийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэргээр шийдвэрлэх Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх Нарийн ногоо даршлах арга технологи эзэмшүүлэх Чацаргана, жимсний мод тариалах
Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай.	Бизнес эрхлэгчдийг дэмжих сургалт зохион байгуулах Орон нутгийн бодлогоор мэргэжилтэн сургаж бэлтгэх.
Санхүүгийн боломж муу	Хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах, дэмжлэг үзүүлэх
Усны хомсдолтой	Ус дутагдалтай газар нутагт худаг уст цэг бариулах

2.1.6. Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсөв, сая төгрөг

Төсөв	2009	2010	2011	2012	2013
Орон нутгийн төсвийн орлого	119061,7	148515,0	183212,9	291937,8	266880,9
Хүн амын орлогын албан татвар /мянга	95 768,8	119 013,8	139 777,7	221 869,1	255 561,7
Бууны албан татвар	604,0	530,0	634,0	730,0	772,0
Ойн гоожин	439,0	264,0	2243,6	1606,5	640,0
Газрын төлбөр	2262,2	2200,0	1213,8	2750,5	2425,0
Ус ашигласны төлбөр	100,0				
Хүү торгууль	20,0		2677,2		
Бусад орлого	19867,7	26507,2	36666,6	64954,7	7482,2
Орон нутгийн төсвийн зарлага	193016,8	197673,5	282086,7	365552,4	392041,8
Цалин	103168,5	105924,2	133378,6	197500,4	215254,4
НДШ,ЭМД	13362,5	11921,9	14673,1	21725,0	23206,6
Гэрэл цахилгаан	858,2	873,3	6692,0	1044,9	1218,0
Тээвэр шатахуун	10824,3	11472,8	21020,1	25217,4	25127,3
Шуудан холбоо	1089,1	1844,9	2161,1	2701,8	5449,6
Албан томилолт	1597,9	4288,4	7543,9	16534,3	12385,3
Бусад зарлага	64119,5	61319,5	105896,4	74752,7	99489,9
Төсвөөс авсан санхүүжилт	72109,9	61399,5	105946,4	74752,7	99489,9

2.1.7. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

/2013 оны байдлаар/

	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.1	Аймгийн төвөөс зай	Км	45
1.2	Улсын нийслэлээс	Км	1800
1.3	Хүн ам төвлөрсөн том зах зээл УБ хот	Км	1800
1.4	Ханган нийлүүлэх төв аймгийн зах	Км	45
1.5	Хилийн гарц БНХАУ Уулаан уул, ОХУ, Улаанбайшинг	Км	80
1.6	Бүсийн төв \Ховд\	Км	300
	2.Нутаг дэвсгэрийн хэмжээ		604,7 мянган га
	Нийт нутаг дэвсгэр	Га	604,7 мянган га
2.1	ХАА-н эдэлбэр газар	Га	465,5 мянган га
2.2.1	Бэлчээр	Га	120,5 мянган га
2.2.2	Хадлан	Га	1120 га
2.2.3	Тариалангийн талбай	Га	45,4
2.2.3.1	Үүнээс тариалдаг талбай	Га	45,4
2.2.3.2	Атаржсан газар	Га	20
2.3	Ойн нөөц	Га	395
2.4	Усны эдэлбэр газар	Га	560

2.5	Тусгай хамгаалалттай газар	Га	137,4
2.6	Зам, шугам сүлжээний газар	Га	1042
2.7	Хот,суурины эдэлбэр газар	Га	296,7
2.8	Уул уурхайн газар	Га	
	Далайн түвшинээс дээш хэдэн метр өндөр	М	1800
3.1	Байгалийн ямар бүсэд хамардаг	-	Алтайн нуруу
3.2	Цаг агаар		
3.3	Жилийн дундаж температур	Градус	
3.4	Зуны дулааны температур	Градус	18
3.5	Өвлийн хүйтний температур	Градус	26,5
3.6	Жилийн дундаж хур тунадас	Мм	300-400
3.7	Хуртай жилийн хур тунадас	Мм	
3.8	Гантай жилийн хур тунадас	Мм	

БАЯН ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН ЕРӨНХИЙ SWOT ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлал хөгжүүлэхэд боломжтойбайгалийн үзэсгэлэнт газрууд, олон нуурголуудтай,өвөрмөцбайгалийнтогтоцтой, аялал жуулчлалын бааз байгуулах боломжтой • Ашигт малтмалын зохих нөөцтэй, унаганбайдлаараа хадгалагдаж байгаа • Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээндхолбогдсон байнгын эрчим хүчний эх үүсвэртэй. • Боловсон хүчний хангалт сайжирч байгаа хүн ам ихтэй • ЖДҮ, бизнес эрхлэх, хөдөлмөр эрхлэх иргэдийнсанал санаачлага идэвхжиж байна • Бэлчээрийн өвөрмөц ургамал нь онцлогтой • Сумын төв болон 2,4- баг дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, өндөр хүчдлийн шугамд холбогдсон • Интернэт мэдээллийн сүлжээнд холбогдсон. 	<ul style="list-style-type: none"> • Газар тариалан хөгжөөгүй • Зах зээлээс алслагдмал, өртөг өндөр • Дэд бүтцийн салбар тэр дундаа зам, харилцаа холбооны хөгжил муу • ЖДҮйлдвэр, үйлчилгээний хөгжил сул, эхлэлийн шатанд байгаа • Ажилгүйдэл, ядуурал дорвитой буурахгүй, иргэдийн амжиргааны түвшин доогуур, амиа аргацаасан байдалтай • Иргэдийнажиллахсонирхолдутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй • Бэлчээр нутаг хязгаарлагдмал • Аялал жуулчлал хөгжөөгүй • Гадаад болон бүс, сум хоорондын харилцаа, хамтын ажиллагаа муу • Сумын ерөнхий төлөвлөгөөгүй

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> • Байгалийнүзэсгэлэн бүрдсэн газруудыгтүшиглэн аялал жуулчлал, гадаад харилцаахөгжих боломжтой. • Төвлөрөл саарч орон нутагт эрх мэдэлнэмэгдэж байгаа • МАА-г хөгжүүлэх мэргэшсэн ажиллах хүч,материаллаг бааз бүрдсэн • МАА-г хөгжүүлэх сонирхол идэвхжиж байгаа 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн эрсдэл, ган зудын давтамж ойртожбайгаа нь ХАА-н салбарт сөргөөр нөлөөл байна. • МАА-н салбараас бусад эдийн засгийнсалбарууд хөгжих нөхцөл бүрдээгүй • Худалдан авах чадвар, борлуулах зах зээлийн багтаамж бага • Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийүнийн өсөлт, өртөг өндөр

2.1.8. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ

Хувийнхэвшлийнажахүйннэгжбайгууллага:Тус суманд нийт 29 аж ахуйн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. ХХК-2, Хоршоо-23, нөхөрлөл-2 тус тус Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл:
Хадгаламж зээлийн хоршоо 1, ХАА-ын чиглэлийн хоршоо 22, худалдаа үйлчилгээний чиглэлийн хоршоо 4, барилгын материалын үйлдвэрлэлийн хоршоо 2, үйл ажиллагаа

явуулж байна.



Дэд бүтэц

Зам тээвэр: Тус сум нь баруунсумуудын дотор зам харилцаа нь сайн хөгжөөгүй. замын чанарын хувьд ердийн шороон замтай. Энэ нь зорчигчдын ая тухтай зорчих нөхцөл байдалд нийцэхгүй болсон. Орон нутгийн зам харилцааны хувьд маш хүндрэлтэй ба сайжруулсан болон хатуу хучилттай зам байхгүй байгаа.

Эрчим хүч: Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон байнгын эрчим хүчний эх үүсвэртэй. Хөдөөгийн 4 баг төвлөрсөн эрчим

хүчний системд холбогдсон ба нийт малчин өрх 100% сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан.



Холбоо: Монголын цахилгаан холбооны салбар 1960 онд ашиглалтанд орсон ба одоогоор сумын төвд 2 ажилтантай үйл ажиллагаагаа тус тус явуулж байна. 2007 онд үүрэн телефоны Мобиком сүлжээ, 2010 онд Юнитель Жи мобайлын зэрэг компаниуд сүлжээгээ оруулсан. Хөххөтөл, Согоог, Даян багт Жи мобайлын сүлжээ орж, ард иргэд ашиглаж байна. 2014 онд шилэн кабелийн шугамд холбогдсон.

Шатахуун түгээх станц:

Сумын төвд 2 шатахуун түгээх станц, Хөххөтөл, Согоог, Ойгор багт 3 шатахуун түгээх станц үйл ажиллагаагаа явуулж байна.



Банкны салбар : Тус сумын төвд ХААН, Төрийн банк үйл ажиллагаа явуулдаг, Хөххөтөл багт Төрийн банкны салбар үйл ажиллагаа явуулж байна.

2.2. Албан байгууллагын товч танилцуулга

2.2.1. Боловсролын салбар



Улаанхус сумын М. Зайсановын нэрэмжит бүрэн дунд сургууль

Тус сургууль нь 1928 онд “Казах хошууны ардын бага сургууль” гэсэн нэртэйгээр байгуулагдсан юм. Анхны багшаар “Алтайхан хошууны” нарийн бичиг Тарваагийн Дүгэрэг, аж ахуйн эрхлэгчээр Өкшебайн Самыхан ажиллаж байсан ба гурван эсгий гэрт 25сурагчтай нэг анги нээж сургалтын үйл ажиллагааг явуулж эхэлсэн байна. Хичээлийн байрны хувьд:

1928 – 1936 онуудад эсгий гэрт, 1936 -1964 онуудад “Кызыл үй” нэртэй модон байшинд, 1964 – 1980 онуудад 440 хүүхдийн багтаамжтай хоёр давхар чулуун байшинд, 1980 оноос одоо хүртэл 640 хүүхдийн стандарт байшинд тус тус хичээллэж ирсэн юм. Бүтэцийн хувьд: 1928 – 1940 онуудад бага сургууль, 1940 – 1950 онуудад дөрвөн жилийн, 1951-1964 онуудад долоон жилийн, 1965 – 1980 онуудад найман жилийн, 1981- 2006 онуудад арван жилийн, 2007 оноос одоо хүртэл 11, 12 жилийн бүрэн дунд сургууль болж өргөжиж байсан. Ардын Их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар 1968 онд “Алтан гадас” одонгоор шагнагдаж байсан ба 1983 онд сургуулийн хүндтэй шавь нарын нэгэн болох генерал Матросын Зайсановын нэрэмжит сургууль болсон. Манай сургуулиас улс, аймгийн хэмжээний олон арван эрдэмтэн мэргэд төрөн гарсан нь Казах түмэний эрдмийн уурхай болсон явдлыг гэрчилэн харуулах юм. Тухайлбал: А.Жамила, Ж.Мухан, С.Ажкен, Д.Женисхан, М.Хашхынбай, Х.Мусахан, Ж.Ром, О.Халхабай, Б.Хурметбек, А.Сарай, О.Тилейхан, М.Хавдыраш, Ш.Ахмет, М.Каримбек, Т.Солтан нарын төр нийгмийн нэртэй зүтгэлтэнүүд, С.Шолтай, Ү.Ахтышхан, Ө.Хамбар, Х.Сураган, К.Хаду, А.Хабылаш, Т.Мухамади, Х.Хузыксей, Д.Таштуан, А.Шабдан нарын гавьяатангууд, К.Оспан, Ахбапи, С.Агат, Н.Жанат, М.Абилмажим, С.Бапаях, С.Гылымхан, У.Набет, Б.Сайболат, Б.Байтей, М.Жанехабыл, Х.Акейхан нарын улс, аймгийн хөдөлмөрийн аваргууд, Ө.Хамбар, А.Минис, Ж.Хайролла, К.Бихумар, С.Жарденбек, М.Алей, А.Магыш, Р.Асай нарын докторууд, М.Хурманхан, Х.Махфуз, Б.Имашхан, Х.Даян, И.Еликбай, И.Нарау, Ж.Баят, М.Наби, М.Хабдай, И.Кенес, П.Мурат, Б.Хызай, Б.Марат, Т.Мүбарак, Б.Тельман, Ы.Беримбай, Ж.Байгалым, К.Баделхан, Ж.Сүйениш нарын зохиолчид, улсын начин Т.Нурхадыл,



аймгийн арслан, М.Борбан, М.Азкей, А.Түгелбай, М.Нажкей, З.Бохай, Х.Алькей, Д.Муралхан аймгийн зан, начингууд Ж.Шайзада, С.Берденбек, Х.Малькей, Х.Жарденбек нарын алдар цолтой бөхчүүд төрөн гарсан нь бид бүхий бахархал мөн.

Сургуулийн захиралаар ажиллаж байсан хүмүүсүүд:

Ажилласан жил	Овог нэр
1928 - 1929	Тарваагийн Дүнгэрэг
1930 - 1934	Кенжебайн Баймухамед, Лхамсүрэн, Х.Тилеуберди
1934 - 1938	Себетийн Шолтай
1938 - 1940	Жилбаагийн Гагаа
1941 - 1942	Ахымын Ахмед
1944 - 1948	Мухашын Хавдыраш
1948-1950	Мами Бекей
1950 - 1951	Яуданы Шайзада
1951- 1952	Малгажы Ламбай
1952- 1955	Үркин Ахтышхан
1955 - 1957	Хулыбекийн Махфуз
1957 - 1958	Дауитбай Бухабай
1958 - 1962	Дөйтений Дарел
1962 - 1964	Хапасын Хожанияз
1964 - 1965	Садугийн Байдолда
1965 - 1970	Женисханы Апенди
1970 - 1973	Жанатын Баят
1973 - 1983	Рамишийн Төкөй
1983 - 1990	Расилийн Хажым
1990 - 1992	Рияны Атимхан
1992 - 1997	Мамырханы Набихан

1997 - 1998	Хайсарын Хаявхан
1998 - 2000	Булшыв Васия
2000 - 2001	Мурсалиманы Бопай
2001 - 2005	Булшыв Васия
2005 оноос	Турсынханы Альхан

Одоо манай сургууль нь 56 багш, 62 техник ажилчид, удирдлагад 4, нийт 122



ажилчидтай, 900 гаруй сурагч, 32 бүлэгтэйгээр сургалт, хүмүүжлийн ажлыг явуулж байна. 16 гэрчилгээтэй кабинет, 6 нэрэмжит кабинет сургалтанд ашиглагдаж байна. 100% мэргэжлийн багшаар хангагдсан ба магистр 4, бакалавр 37, дипломын 15 багш байгаа ба заах аргач 17, тэргүүлэх зэрэгтэй 12 багш, боловсролын тэргүүний ажилтан 13, алтан гадас одонт 3, хөдөлмөрийн

хүндэт медальтай 6 багш ажиллаж байна. Дундахлах ангиудын сургалтын менежер Т.Ташкен – монгол хэлний багш мэргэжилтэй, бага ангийн сургалтын менежер З.Бердибек – бага ангийн багш мэргэжилтэй. Нийгмийн ажилтан Х.Даурен, ня-бо Х.Рашат нар ажиллаж байна.

Улаанхус сумын Хөххөтөл багийн Бүрэн бус дунд сургуулийн танилцуулга

Тус сургууль нь 1938 онд анх үндэс суурь нь тавигдсан байдаг. Анхны багш бөгөөд захирал Гавьяат багш, доктор, спрофессор Б.Хурметбек ажилласан. 1944- 1976 оны хооронд тус сургуулийг Согогын сургуульд хоёр удаа нийлүүлж, 1976 оноос ард иргэдийн хүсэлтийг үндэслэн Хөх хөтөлийн бага сургууль нэртэй дахин байгуулсан.



1944 онд сургуулийн анхны захирал бөгөөд багш нь Д.Дарел дараа нь Д.Ажик гэдэг хүмүүсажиллаж байсан ба сургуульд голдуу 10-14 насны хүүхдүүд хамрагджээ. 1945- 1946 оны хичээлийн жил нь 8-р сарыш 5-нд

эхэлж 3-р сарын 25-нд дуусчээ. Сургуулийн захирал Хавылгазы ажилласан бол 1949- 1950 оны хичээлийн жилд Согогын сургуулиас дахин салгаж Хөх хөтөлийн бага сургууль байгуулагдан захирлаар нь Бугабай ажилласан байна, 1950-1951 оны хичээлийн жилд захирал Байдолда байсан ба 1951 - 1953 онд Камелеш, 1953 - 1954 онд Хапсатор, Авдкерим ажилласан бол дараа нь Бөкей, Шадет, Расол, Шкал 1974 -1975 оны хичээлийн жилээс эхлэн тасралтгүй 1991- 1992 оны хичээлийн хияхүртэл Ардын боловсролын Тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медальт Жахия овогтой Хавылгах ажиллаж өндөр насны тэтгэвэрт гарсан байна. Дараа нь Алтан гадас одонт, Боловсролын тэргүүний ажилтан Жанат овогтой Байтан, Боловсролын тэргүүний ажилтан Хумархан овогтой Ахай, Алтан гадас одонт Бахтыбай овогтой Хызай ажиллаж байсан бол сургалтын менежерээр "Хөдөлмөрийн гавъяны улаан тугийн одонт" Т.Бауден ажилласан. Тухайн жилүүдэд Муталив, Х.Жупархан, М.Игилик, Хожабай, Гүлжайна, Комисхан, Алданыш, Х.Хумаргажы, Т.Нурсалхан, Бопалай, Б.Саханай, Д.Нарау, А.КамеЙ, А.Шампия, Х.Балапан, Захан, Х.Саней, О.Ережен, Алөлеу, Т.Күлмесхан, Ербала, Ү.Мыхтыбай, С.Жухан, Х.Төлеген, С.Байсалхан зэрэг ахмад буурлууд сургуулийн үйл ажиллагааг тогтмол явуулж өдий хүрэхэд нь ихээхэн хувь нэмрээ оруулсаныг түүх гэрчилнэ.

2000- 2001 оны хичээлийн жилээс эхлэн 20012 - 2013 оны хичээлийн жил хүртэл Алтан гадас одонт, Спортын олон улсын хэмжээний мастер Риян овогтой Атимхан сургуулийг удирдан захирлаар ажилласан.



Р.Атимхан захирлаар ажилласан хугацаандаа сургуулийн материаллаг бааз бэхжиж

сургалт хүмүүжлийн ажлыг орчин үеийн шинэ техник, технологи ашиглаж явуулах боломж бүрдсэн байдаг. Үүнд сургуулийн 9 такхимтай, 275 хүүхдийн суудалтай хичээлийн шинэ байр, биеийн тамирын заал, 50 ортой хүүхдийн дотуур байр, соёлын төв дотуур байрны хүүхдийн хоолны газар, халуун ус зэрэг барилгууд баригдан ашиглалтанд орсон. Энэ хугацаанд сургалтын менежерээр М.Алтангэрэл, К.Салтанат нар ажилласан. Түүнээс гадна сургуулийн няравын ажлыг олон жил хашиж үр бүгээлтэй ажиллаж байгаа хүн Х.Кандидат юм.

2012- 2013 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн захирлаар Шухамай овогтой Молданияз ажиллаж байгаа. Одоо тус сургуульд 400-аад сурагч, 86 багш, ажилчидтайгаа үйл ажиллагаагаа явуулж байгаа ба дотуур байранд 200-аад хүүхэд амьдарч байна. 2013- 2014 оны хичээлийн жилд 150 хүүхдийн дотуур байр баригдаж байгаа ба биеийн тамирын заалны дутуу байсан Чийрэгжүүлэлтийн танхим баригдан ашиглалтанд орсон юм.

Монгол Улсын Гавьяат багш С. Шолгайн нэрэмжит Ойгор бүрэн бус дунд сургууль

Ойгор дунд сургууль нь анх 1946 онд "Ойгорын бага сургууль" нэртэйгээр 2 багш, 46 сурагчтай байгуулагдсан байна. Сургуулийн анхны эрхлэгч О.Хабылгазы, хичээлийн



эрхлэгч
С.Шайзада,
багшаар
С.Хамбар,
Х.Хусайн нар
ажиллан 2 эсгий
гэрт үйл
ажиллагаагаа
эхэлсэн байв.1947
онд нэгдлийн
хөрөнгөөр 5
ангитай
хичээлийн байрыг
барьж босгон
ашиглаж байгаад
1961 онд анх удаа
биеийн тамирын
заалтай шинэ
хичээлийн

байранд хичээллэж эхэлсэн байна.Хуучин хичээлийн байрыг дотуур байр болгож дотуур байранд хүүхэд авч эхэлсэн байна.Энэ үеэс эхлэн сургалтын чанар сайжирч хүүхдийн элсэлт нэмэгдсэн байна.Үүний үр дүнд Ойгорын бага сургууль 1977 онд "Улсын тэргүүний" сургуулиар шалгарсан байна.

Энэ үед тус сургуульд 1972-1989 он хүртэл бага сургуулийн эрхлэгчээр ажиллаж байсан Т.Бауден сургуулийн материаллаг бааз , сургалтын орчны нөхцөлийг сайжруулахад жинтэй чувь нэмэр оруулсан байна.Тухайлбал дулааны уурын зуух бариулж, дотуур байрыг туслах аж ахуйтай болгон , сүү сүүн бүтэгдэхүүнээр хзнгаж, 17 шинэ туршлагыг бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлсэн байна.

Ийнхүү сургалтын орчны бааз бүрдсэн учраас 1991 оны 9 сарын 15 ны өдрөөс эхлэн ард иргэдийн хүсэлтээр 8 жилийн сургууль болон өргөжсөн байна.

1996 онд сургуулийн 50 жилийн ойн баяраар Засгийн газрын 234 дугаар тогтоолоор Монгол улсын Гавьяат багш Себетийн Шолтайн нэрэмжит сургууль болсон билээ.

Тус сургуульд Монгол Улсын Гавьяат багш С.Шолтай, Ү.Ахтышхан "Боловсролын тэргүүний ажилтан" Д.Дарель, К.Хайнел ,Ж.Хавылкак,А.Расол, Б.Абдикерим, А.Мамай, Б.Камалаш, Б.Халамхан.Т.Бауден, Х. Ахылай Х.Тайран, Х.Даулет, Ж.Баатаржав нар захирал эрхлэгчээр ажиллан сургуулийн хөгжил цэцэглэлтэнд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.

Мөн сургуулиас төр нийгмийн зүтгэлтэн Б.Хурметбек , А.Сарай, А.Сонгыбай, Ш.Жүкей С.Шанас, Х.Тау, А.Мамзй, А.Кантарбай, Ш.Дулат, К.АкрасАрдын Бага хурлын дэд



дарга , нэрт мэс засалч Х.Хузыкай , УИХ-ын гишүүн Х.Володя , Ардын Их хурлын депудат А.Акбапи, О.Болысбай, С.Агат, Улсын гавьяат жүжигчин Х.Хаду, Улсын аварга малчин С.Гылымхан, Улсын 2 удаагийн аварга тариаланч Х.Масгут, эрдэмтэн К.Бихумар, А.Сьез зохиолчид Ж.Баят, М.Хавдай, П.Мурат, Б.Марат, Ж.Байгалым, Ш.Мурат аймгийн арслан Д.Муралхан , Х.Шайзада аймгийн заан Д.Маралбек зэрэг алдар цуутай хүмүүс төрөн гарсан иб хамт олны бахархал мөн.

Тус сургуульд холбоотой онцлогоос дурдвал жил бүр шинэ хичээлийн жилийн



нээлтийн баярыг ёс төгөлдөр тэмдэглэхээс гадна тус сургуулийн шавь байсан төр нийгмийн зүтгэлтэн, яруу найрагч Пушатайн Муратын нэрэмжит даагын уралдаан зохион байгуулж түрүүлсэн даагыг медалиар шагнадаг уламжлалтай юм.

Мөн 2010 оноос дотуур байрны хүүхдүүдийг эрүүл

хүнсний ногоогоор хангах зорилгоор газар тариалангийн талбайтай болсон.Энэ ажилд гадаадын хөрөнгө оруулалтаар 40 сая төгрөг зарцуулагдсан ба уг санхүүжилтийн хүрээнд 5 га газрыг хашаалан хамгаалж, 10х40 хэмжээний хүлэмж, усжуулах систем, гүний худаг баригдсан юм.Үүний үр дүнд *дотуур* байрны хүүхдүүдийг чанартай хүнсний ногоогоор хангадаг.2013 оны 9-сарын намрын ургац хураалтаар 8 тонн төмс, 2 тонн гаруй бусад төрлийн хүнсний ногоо бэлдэж "Сумын тариаланч" хамт олноор шалгарч байна.

Боловсролын багц төслийн хүрээнд 2012 онд 11 сая төгрөгийн санхүүжилт авч биеийн тамирын заалны шалыг сольж, хөдөлмөрийн кабинетийн техник хэрэгсэлийг авч, төслийг хамгийн сайн хэрэгжүүлэн сургуулиар шалгарч, нэмэлт санхүүжилтээр 16 сая төгрөгөөр шагнагдсан болно.Энэхүү санхүүжилтээр 2013 онд мэдээлэл зүйн кабинетийг тохижуулж 10 ширхэг компьютер, принтер мөн дотуур байранд ширээ сандал, гал тогооны тоног төхөөрөмжийг худалдан аваадбайна.

Суурь боловсролын үйлчилгээний SWOT

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Хичээлийн болон дотуур байрны барилга хүрэлцээтэй, сайн • Багшлах боловсон хүчний хүрэлцээ сайн, ур чадвар сайн,өндөр • Материаллаг бааз, компьютер, техник хэрэгслийн хүрэлцээ хангамж сайн • Цахилгааны эх үүсвэртэй • Нэг ээлжээр хичээллэдэг, нэг танхимд ноогдох суралцагчийн тоо цөөн учир сурагчдад үзүүлэх хүртээмж өндөр • Эвсэг хамт олонтой • Интэрнэтэд холбогдсон 	<ul style="list-style-type: none"> • Сурагчдын чөлөөт цаг өнгөрөөх, биеийн тамир, урлаг, соёлын техник хэрэгслүүд дутмаг • Сургуулийн нийт төсөв хүрэлцдэггүй • Одоо хэрэглэж байгаа нам даралтын зуух түлш их хэрэглэдэг • Боловсролын салбарын хэмжээнд сургалтын зардал хүрэлцээгүйгээс багш ажилчдыг чадваржуулах, дадлагажуулах сургалт хангалтгүй • Цэвэр бохир ус, халуун усны асуудал шийдвэрлэгдээгүй • Чийрэгжүүлэлтийн өрөө багаж, төхөөрөмж байхгүй
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Багш нарын мэргэжлийг ажлын байранд дээшлүүлэх боломж бүрдсэн • Сургууль эцэг эхийн холбоо сайн • Оюунлаг хүмүүс, төгсөгчдөөс дэмжлэг авах боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Боловсролын шинэчлэлийн талаархи иргэдийн ойлголт харилцан адилгүй • Шилжилт хөдөлгөөний улмаас суралцагчдын тоо буурах хандлагатай • Үнэ ханшны өсөлтөөс төсвийн дутагдал нэмэгдэж байна

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга
--------------------------------	--

	ХЭМЖЭЭНҮҮД
Кабинетийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй, хангалтгүй	Хичээлийн кабинетүүдийг иж бүрнээр стандартын дагуу тохижуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
Алслагдсан байдал, боловсролын хүртээмж чанар хангалтгүйгээс шилжилт явагдаж суралцагчийн тоо буурах хандлагатай байна.	Боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадваржуулах, хариуцлагыг нэмэгдүүлэх Иргэдийн оролцоо, идэвхийг сайжруулж хамтын ажиллагааг нэмэгдүүлэх Үйлчилгээний автомашинтай байх
Дотуур байр, галтогооны тохижилт, засвар үйлчилгээ сайнгүй	Дотуур байр, галтогооны тохижилт, засварыг сайжруулах төсөл, хөтөлбөрт хамрагдах
Интернэтэд холбогдоогүй	Интернэтэд холбогдож мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх

УЛААНХУС СУМЫН СӨБ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Тус сумын хүүхдийн цэцэрлэг нь 1961 онд “Алтайн хөгжил” нэгдлийг түшиглэн нэгдлийн төсөвтөй, нэг бүлэг 25 хүүхэд, 3 ажилтантай үйл ажиллагааг эхэлсэн байна. 1973 оноос улсын төсөвтөй 2 бүлэг 50 хүүхэд 7 ажилтантай ажиллаж байсан бол 1974 оноос 3 бүлэг 75 хүүхэд 11 ажилтантай тус тус үйл ажиллагаагаа явуулж байсан.

Тус цэцэрлэг нь 1991 онд ажлын амжилтаар Улсын тэргүүний цэцэрлэгээр

шалгарч байсан ба 2007, 2010 оны ажлын үр дүнгээр аймгийн хэмжээнд 2 дугаар байранд шалгарсан. 2009 онд ажлын амжилтаар аймгийн хэмжээнд 5-р байранд шалгарч байсан. 2012 -2013 оны хичээлийн жилд 215 хүүхдийг сурган хүмүүжүүлж эрхлэгч, арга зүйч 19 багш 20 туслах ажилтан ажиллаж байна.

Одоо тус байгууллагын багш ажилчид бүгд мэргэжилтэй бөгөөд мэргэшсэн туршлагатай байхаас гадна өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан тефлица барьж, ногооны талбайг өргөтгөж, өргөст



хэмх, төмс, лууван,улаан лооль, шар манжин зэрэг ногоонуудыг тарьж хоол хүнсэнд хэрэглэж байна.Мөн хүүхдийн тоглох талбайд эцэг эхтэй хамтран тоглоомын тоог нээгдүүлэн, мод тарьж, зүлэгжүүлэн ажилчдын идэвхи санаачилгатай ажиллаж байна. Аймаг сумаас явуулдаг ямар ба үйл ажиллагаанд хамт олон идэвхи зүтгэлтэй оролцож эхний байранд шалгарч оролцож байдаг.

“Балбөбек” хүүхдийн цэцэрлэгийн танилцуулга



Тус “Балбөбек” цэцэрлэг нь 2006 оны 4-р сард Цэцэрлэгийн багш мэргэжилтэй С. Күлшашын санаачлагаар Америк улсын иргэн сайн санаат Варвара Леонардагийн санхүүжилтээр Согоог багийн иргэдийн дэмжлэгийг авч анх байгуулагдсан.

Уг цэцэрлэг байгуулахад шаардагдах орон байр, багшлах боловсон хүчний судалгааг гарган ээхний ээлжинд 2 эмэгтэй багшийг сонгон авч, Улаанбаатар хотод

суралцуулан орон нутгийн иргэдээс 7 хүнийг нэмж авч 3 сар цалингүй ажиллаж үйл ажиллагааг эхлүүлж байсан.

Сайн санаат Америкийн иргэн Варварагийн тусламжтайгаар 4 багш, 6 ажилтан, 50 хүүхэд, 2 бүлэгтэйгээр аймгийн хэмжээн багийн төвд нээгдсэн анхны цэцэрлэг болсон.

Тус цэцэрлэг 2007 онд улсын бүртгэлд бүртгэгдэн улсын төсвөөс санхүүжилт авч эхлэсэн юм.



Хөххөтөл багийн хүүхдийн цэцэрлэгийн танилцуулга

Хөх хөтөл цэцэрлэг 2007 онд 4-р багийн “Баобөбек” цэцэрлэгээс өрх тусгаарлан анх байгуулагдсан Одоо багш 3, туслах 3, үйлчилгээний ажилчин 12 нийт 3 бүлэгт 75 хүүхэд хүмүүжиж байна. Одоо сургуулийн хуучин барилгад үйл ажиллагаа явуулж байна.

2012 оны 8-р сарын 20-нд тусгай зөвшөөрөлтэй хүүхдийн цэцэрлэгийн эрхийг авч 3 бүлэг 70 хүүхэд, 18 багш ажилчдын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

2.2.2. СӨБ-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Багш ажилчид ажиллах болон хүүхдүүдийн сурч, хөгжих боломж сайтай тохилог, дулаахан, цэвэрхэн орчинтой • Бүтээлч санаачлагатай, эвсэг хамт олон бүрдсэн. • Багш ажилчид харьцангуй тогтвор суурьшилтай ажилладаг. • Багш, ажилчид мэдлэг боловсролоо дээшлүүлэх эрмэлзэлтэй. • СӨБ-д хамрагдаагүй хүүхдийг сургуульд бэлтгэх талаар санаачлага гарган ажилладаг. • Мэргэжлийн удирдлагатай. <p>.2.</p>	<ul style="list-style-type: none"> • Төсвийн хүрэлцээ муу • Сургалтын техник хэрэгсэл дутагдалтай. • Хэрэглэгчдийн хүсэж буй бүжиг, дуу, экологи, сэтгэхүй хөгжүүлэх чиглэлийн гүнзгийрүүлсэн сургалттай анги байхгүй • Бүлэг дүүргэлт нь нас насаараа байдаггүй холимог бүлэг ажилладаг • Хүүхдийн дунд дугуйлан хичээллүүлдэг боловч үр дүнд хүрэхгүй байгаа. • Гэр цэцэрлэгийн үйл ажиллагаа харилцан адилгүй, тогтмолжоогүй.
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> • Туслах аж ахуйхөгжүүлэх • Олон улсын байгууллагаас төсөл бичиж хөрөнгө босгох • Сургууль, эцэг эхтэй хамран ажиллах, гадаад, дотоод харилцааг өргөжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Багш нар нэг газар хэт удаан ажилласнаас ажлын амжилт саарах хандлагатай • Алслагдмал багийн хүүхдүүд цэцэрлэгт хамрагдах боломжгүй

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай	Хөрвөх болон мэргэшүүлэх, давтан сургалтанд хамруулах зэргээр мэргэжлийн боловсон хүчнээр хангах Мэргэжлийн сургууль төгсөгчдөөс сонгон шалгаруулж авах
Цэцэрлэгийн шинэ байранд ороход бэлтгэл ажил хангах, техник хэрэгсэл, материаллаг эд зүйлсээ шинэчлэх	Төсөл хөтөлбөрт хандах замаар хатуу зөөлөн эдлэл, бусад эд зүйлсээ шинэчлэх Гал тогооны цахилгаан хэрэгсэл авах
Гадна талбайг хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулах	Мод тарих Төсөл хөтөлбөр, өөрийн нөөц боломжоор тоглоомын талбай байгуулах
Гэр цэцэрлэгүүдийн ажиллагааг эрчимжүүлэх	Үйл ажиллагааг нь цагт нь эхлүүлэх Багш нарыг мэргэшүүлэх

2.2.1. Соёлүйлчилгээ



Сумын Соёлын төв

Одооноос 58 жилийн тэртээ 1946 онд тус сумын соёлын төсийн үндэс суурь нь тавтдаж, ард иргэдийн дунд соёлын үрийг тарих үйлсэд хүчин зүтгэж эхэлсэн билээ. Анх байгуулагдсан соёлын төвийг Күмис нэртэй эмэгтэй хүн санаачлан "Улаан гэр" нэртэй байгуулж байжээ. Түүнээс хойш энэ байгууллагад Аким, Камалаш, Хамархан, Картош, Хавдыраш, Бердиял А. Өтей нарын урлаг соёлын авьяастнууд ажиллаж удирдаж байв. 1965 онд тус төвийг "Улаан булан" гэж нэрлэх болжээ. 1965-1972 онуудад эрхлэгчээр Х.Риян,

М.Ахыби нар нь ажиллаж байсан ба мөн Т.Мубарак, М.Дария, Х.Зархумар, А.Хазидолда, Б.Ораз, З.Охай, М.Ажахай, М.Байдолда, Бөкей, Х.Унат, Х.Санайхан, С.Ардах, Х.Лашпан, С.Жанылсын, З.Солтан, Жаман нарын алтан үеийн ахмад шилдэгуран сайханчид ажиллаж байв. Улмаар сумын соёлын байгууллага улам хөгжиж, 1972 онд орчин үеийн хийцтэй хөгжмийн зэмсэг, гэрлэн төхөөрөмжүүдээр бүрэн тоноглогдсон шинэ клубтэй болсон юм,

1973-1979 онуудад тус клубын эрхлэгчээр Ш.Орал, С.Жумахан, Х.Химадил, Ж.Танатар, 1980-1983 онуудад Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан Б.Хандсүрэн ажиллаж, уран сайханчдаар Т.Мубарак, Б.Ораз, Ү.Баян,Ө.Жанимхан, Х.Унат, Б.Шерикбай, Х.Алтай^,Бауыржан, Х. Агылан, С.Бахыт, М.Зукан, КЗаманбек, С.Гулбаршын, Х.Гүлбахыт, М.Күлимхан нарын хөгжимчид,Б.Ризабек, Р.Март, М.Тилек нарын дунд үеийн уран сайханчид үр бүтээлтэй ажиллан Соёлын яамнаас зарласан уралдааны болзлыг ханган биелүүлсэнээр "Ардын театр" болон өргөжсөн юм.1983-1985 онуудад тус театрт М.Пермагамбет, Х.Тауысхан, хөгжмийн багш Б.Шерикбай нар удирдаж язгуур урлагийг хөгжүүлэх, тэр тусмаа урлаг соёлын залуу авьяастнуудаар хамт олноо бүрдүүлсэнээр тус театрын уран бүтээлд чанарын өөрчлөлт гарч, хөгжлийнхээ шинэ үеийг эхэлсэн юм, 1986- 2002 онуудын хооронд эрхлэгчээр нь Б.Шерикбай,уран сайханчаар М.Серик, М.Тилек, М.Айгүл, М.Мария, З.Болат, Б.Ризабек нар ажиллав.

1983 онд Театрын дэргэд "Самгау" эстрад хамтлаг байгуулж үйл ажиллагаагаа

эхэлсэнээр театрын уран бүтээл эстрад концерт, язгуур урлаг, үзэгдэл жүжгийн төрлүүдээр бэхжин орон нутгийн болон хөдөөгийн хөрш Орос улсын Хош-агааш районы соёлын байгууллагатай хамтран ажиллаж ирлээ.Номын санчаар Т.Махан, Ш.Наадамгүл нар



ажиллаж байсан бол, одоо А.Зауре үр бүтээлтэй ажиллаж байна, Тус театраас Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан Х.Парад, Б.Муратбек тэргүүний уран сайханчид Б.Шерикбай төрөн гарсан юм. Залуу уран бүтээлчид Ж.Даулетхан, Ж.Сүйениш нар нь бидний бахархал юмаа. 2003 оноос бүтцийн өөрчлөлт хийж, "Соёл гэгээрлийн төв" болон зохион байгуулагдаж эрхлэгчээр нь Б.Гүлжазира ажиллаж байв.

2003 8-р сард Говь Алтай аймагт болсон баруун бүсийн урлагийн наадамд амжилттай оролцож 2-р байранд шалгарсан. 2003 оноос соёлын төвийн эрхлэгчээр Х.Парад, Хөгжмийн багшаар З.Тунгышбек, номын санчаар А.Зауре нар ажиллаж байв. 2007 оноос эрхлэгчээр Х.Парад, номын санчаар А.Зауре, хөгжмийн багшаар З.Тунгышбек, бүжгийн багшаар Т.Ахылбек, туслах ажилчинаар Б.Ризабек нар ажиллаж байжээ. 2011 оноос эрхлэгчээр Х.Парад, номын санчаар А.Зауре, хөгжмийн багшаар Т.Ахылбек, бүжгийн багшаар С.Ерлан, туслах ажилчинаар Н.Маирагүл, галчаар А.Ердигали, Д.Жанарту нар, Мөн 2014 оноос эрхлэгчээр Т.Ахылбек, хөгжмийн багшаар П.Бектас бүжгийн багшаар С.Ерлан, номын санчаар А.Зауре, туслах ажилчнаар Н.Майрагүл, галчаар А.Ердигали, Д.Жанарту нар тус тус ажиллаж байна

Эрүүл мэндийн үйлчилгээ:

УЛААН ХУС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Абзал ажилласан.

Тус эмнэлэг анх 1932 онд 1 эсгий гэртэй ,4 ортой,бага эмч 1,сувилагч 1,асрагч 1,орчуулагч 1 гэдэг орон тоогоор анх байгуулагдаж анхны эмчээр Хочча Сараев гэдэг орос эмч ажиллаж байжээОрос эмч 1938 он хүртэл ажилласан.1939 оноос бага эмч Лонжгой ажилласан орны тоо 1932 оноос 1957 он хүртэл бага эмчийн салбар нэртэйгээр ажиллаж 19... онд анх их эмчийн салбар 9 ортой,14 орон тоотойгоор байгуулагдаж анхны эмчээр их эмч

Их эмчийн салбар 1957-1962 он хүртэл ажиллаж 1963 оны 9-сард сум дундын эмнэлэг 25 ортой 22 ажилчинтай байгуулагдаж их эмч 3,рентген техникч 1, бага эмч 2,лаборант 1,сувилагч 5 бусад ажилтан 10 хүн ажиллаж 3 сумыг хариуцаж эрхлэгчээр Набихан, их эмч Ядмаа нар ажиллаж байв.

Сум дундын эмнэлэг 1970 он хүртэл ажиллаж 1970 оны 8-сарын 1 нд аймгийн ЭХГазрын тушаалаар их эмчийн салбар болж эрхлэгчээр Хадиша ,дүн бүртгэлийн эмчээр Дакей нар ажиллаж байв.

1971 онд их эмчийн салбар нь 25 ажилчинтай 3 бага эмчийн салбартай үйл ажиллагаа явуулав. Үүнд Хөх хөтөлд 1 /эрхлэгчээр Хамбар/, Ойгорд 1 /эрхлэгчээр Төлеу/, Даянгийн 4-бригадад 1 /эрхлэгч Мустапа/ бага эмчийн 3 салбар ажиллаж байв.



1972 онд эрхлэгчээр Хадиша ажилласан. 1974 оноос 1981 он хүртэл эрхлэгчээр их эмч Набихан, их эмч Марат, их эмч Татьяна нар ажилласан байна.

1992 оноос 2005 он хүртэл эрхлэгчээр Ү Даурет, 2005 оноос 2006 он хүртэл 3 Мухтар, 2006-2008 он хүртэл Т Жанболат, 2008 оноос 3 Мухтар нар ажиллаж байна. 1972 оос 2012 он хүртэл

их эмчийн салбар, 2012 оноос сумын эрүүл мэндийн төв нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл мэндийн төв нь 7-р багт байршилтай 34 ортой Их эмч 5, тусгай мэргэжилтэн 25, туслах ажилтан 26 ажиллагсадтай 2003 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй, 2 давхар зориулалтын барилга. Инженерийн бие даасан хангамжтай.

Хүн эмнэлгийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Хүний нөөц хангалттай • Эмч мэргэжилтний мэдлэг чадвар сайн. • Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагддаг. . • Өөрийн халаалтын системтэй 	<ul style="list-style-type: none"> • Их эмчийн тогтвор суурьшил муутай./ 2-3 жил • Багийн эмч нар багтаа байрладаггүй. • Гадны хандивлагч нарт төсөлбичдэггүй. • Оношлогооны ба тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй. • Хүн амын эрүүл мэндийн боловсрол дутмаг. • Интернетэд холбогдоогүй.
Боломж	Саад бэхшээл
<p>Эрүүл монгол хүн хөтөлбөр хэрэгжиж байгаа</p> <p>Сумын орон нутгийн хөгжлийн сангаас мөнгө хувиарлаж байгаа</p> <p>Аймагт ойрхон</p>	<ul style="list-style-type: none"> • Багууд нь сумаас алслагдсан • Санхүүгийн хязгаарлагдмал байдал. • Багийн айлууд хэт хол байрладаг • Замын нөхцөл муу байдаг учраас түргэн тусламж үзүүлэхэд хүндрэлтэй байдаг

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг	Рентген, физик эмчилгээ, зайн оношилгооны болон бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах
Хүүхдийн мэргэшсэн эмч олддохгүй байгаа	Хүүхдийн болон нарийн мэргэжлийн эмч нартай болох бүх талын арга хэмжээ авах
Шинжилгээний нэр төрөл хэт цөөн	Оношилгоо, шинжилгээний лаборатортай болох
Эмийн сангийн стандартын байргүй	Эмийн сангийн байрыг шинэчлэн стандартад нийцүүлэх
Иргэдийн эрүүл мэндийн боловсрол тааруу	Сургалт сурталчилгааг өргөтгөх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, чийрэгжүүлэлтийн олон талт арга хэмжээ авах

Улаанхус сум дахь цагдаагийн хэсэг

Улаанхус сум дахь цагдаагийн хэсэг нь 2010 оны 12-р сард ЦЕГ-ын даргын 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 672 тоот тушалаар



батлагдсан ба тус сум дахь цагдаагийн хэсэг байгуулагдсанаас хойш Хэсгийн дарга цагдаагийн ахлах дэслэгч Н.Досжан, мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч С.Ерболат хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Даулен жолооч цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Н.Архалах зохицуулагч

цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ш.Нурлан зэрэг 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ТУСГАЙ САЛБАР

1992 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Батлан хамгаалахын сайдын н/11 тоот



тушаалаар Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт байгуулагдсан.

1992 оны 09 дүгээр сарын 23-нд ЗХЖШ-ын даргын н/46 тоот тушаалаар байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж эхэлсэн.

Улс орны нийгмийн байгуулалт өөрчлөгдөн, батлан хамгаалах бүгэц зохион байгуулалтанд орсон өөрчлөлтийн дагуу Монгол Улсын баруун хойд бүс буюу ОХУ-тай хил залгаа

бүсүүдийн агаарын хилийг хамгаалах болон олон улсын агаарын нислэгийн маршрут нээгдсэнтэй холбогдуулан тус салбарыг байгуулах шаардлага тулгаран гарч ирсэн.

Тус салбар нь Баян-Өлгий аймагт байгуулагдсан Зэвсэгт хүчний анхны нэгж бөгөөд үүгээрээ цэрэг армийг ард түмэндээ ойлгон танилцуулах цэрэг иргэний олон талт харилцааг бэхжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсний дээр байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх, ард иргэдийг гамшиг ослоос авран хамгаалах үүргүүдийг хэрэгжүүлж байна.

Салбарын бие бүрэлдэхүүнээс Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд ахлагч Т.Батдэлгэр Афганистан улсад 2 удаа, дэслэгч А.Сүрэнхүү, ахлагч Г.Цагаандалай нар Афганистан улсад, ахлагч Д.Абай, ахлагч А.Айгажы, ахлагч Х.Бахытболат нар БНӨСУ-д, ахлах ахлагч З.Нурбек, ахлагч Х.Каким, дэд ахлагч А.Кадирбек нар Серро-Лион улсад тус бүр үүргээ амжилттай гүйцэтгэсэн ба одоо ахлах ахлагч А.Бахытбек БНӨСУ-д үүргээ амжилттай гүйцэтгэж байна. БХЯ,ЗХЖШ-ын болон командлалын, төгсөлтийн шалгалтуудад жил болгон байнга “сайнаас онц” үнэлгээтэй шалгагдаж байсан.

Зэвсэгт хүчний аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд жолооч энгийн Х.Серик амжилттай оролцож “Хүрэл” медалиар, радиотелеграфчин энгийн Э.Түвшинжаргал Зэвсэгт хүчний аварга шалгаруулах өвлийн спортын цанын тэмцээнд тус тус амжилттай оролцов.

Байлдааны болон олон талт тусгай үүрэг гүйцэтгэх бүлгийн зааврын дагуу бүлгийн бие бүрэлдэхүүнийг материал табель хэрэгсэлээр хангаж, дадлага сургууль хийлгэн орон нутгийн чанартай гал, түймэр, шар усны үер, өндөр хүчдлийг сэргээн босгох ажлуудад идэвхитэй оролцож ирсэн.

Манай бие бүрэлдэхүүн салбарынхаа түүхт 20 жилийн ойдоо ажил хөдөлмөр, сурлага, спортын өндөр амжилтаар бэлэг барихаар ажиллацгааж байна.

1995 онд ЗХЖШ-ын дарга хошууч генерал Дамдинсүрэн, ЗХЖШ-ын АДХЦ-ийн командлагч хурандаа Ц.Бямбажав нар ирж салбарын ажил байдалтай танилцсан.

Тус салбарт 2000 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөхий командлагч Нацагийн Багабанди зочилсон

2001 оны 11 дүгээр сард Батлан хамгаалахын дэд сайд Ц.Тогоо тус салбарт зочилж салбарын ажил байдалтай танилцав.

2003 оны 03 дугаар сард нийт офицер, ахлагч нарт аттестатчиллын шалгалт явагдаж, шалгалтын комиссын даргаар хорооны захирагчийн I орлогч, штабын дарга дэд хурандаа В.Лувсанпүрэв тэргүүтэй комиссын гишүүд ирж шалгасан болно.

2003 оны 01 дүгээр сард Батлан хамгаалахын сайд Монгол Улсын баатар, анхны сансарын нисгэгч Ж.Гүррагчаа, УИХ-ын гишүүн Далайхүү, Сандалхан, Нигмет тэргүүтэй засгийн газар, УИХ-ын төлөөлөгчид ирж тус салбарын үйл ажиллагаатай дэлгэрэнгүй танилцаж үүрэг даалгавар өгч явсан.

2004 оны 2-р сард ЗХЖШ-ын даргын орлогч, ЦТГ-ын дарга хошууч генерал Б.Эрдэнэбат тэргүүтэй ЗХЖШ-ын шалгалтын комисс тус салбарын ажил байдалтай танилцаж зэвсэг техникийг шалгаж явсан.

2004 оны 06 дугаар сард УАДХЦ-ийн командлагч хошууч генерал Ч.Улаанхүү тэргүүтэй, мөн ЗХЖШ-ын санхүүгийн хэлтэс, хорооны удирдлагаас хүмүүс ирж ажил байдалтай танилцав.

2004 оны 10 дугаар сард ЗХЖШ-ын I орлогч дарга хошууч генерал Борбаатар тэргүүтэй шалгалтын комисс ирсэн.



2010 оны 03 дугаар сард ЗХЖШ-ын ЦХҮГ-ын дарга хурандаа Даваа, барилга орон сууцны хэлтэсийн дарга хурандаа Баярсайхан, БХЯ-ны санхүүгийн хэлтэсийн мэргэжилтэн Нямсамбуу нар ирж үйл ажиллагаатай танилцсан.

2011 оны 01 дүгээр сард БХЯ-ны сайд, УИХ-ын гишүүн Л.Болдоор ахлуулсан УИХ-ын гишүүд Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Зоригт, УИХ-ын гишүүн З.Энхболд, Жекей, Тилейхан, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Ц.Бямбажав тэргүүтэй бүрэлдэхүүн ирж тус салбарын ажил байдалтай танилцав.

Одоо тус салбарын удирдлагаар салбарын захирагч ахлах дэслэгч Э.Болор-Эрдэнэ, захирагчийн орлогч, зэвсэг техникийн дарга ахлагч дэслэгч С.Баатар, салааны захирагч дэслэгч А.Сүрэнхүү, Б.Отгонжаргал, нууцын дарга ахлах ахлагч Ж.Баатаржаргал, аж ахуйн дарга ахлах ахлагч М.Мейрбек нар ажиллаж байна.



Байгаль орчны салбарын хөгжил

Улаанхус сумын нутаг бүхэлдээ уулархаг бүсэд хамрагдах бөгөөд ургамал газарзүйн ангиллаар Алтайн нурууны тойрогт ордог. Ан амьтнаар баялаг, элбэг тохиолдох махчин амьтдаас үнэг хярс, дорго, мануул мэрэгчдээс үлийн цагаан оготно, олби, орог саарал, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Уул нутагт байнга оршин суудаг шувуудаас бүргэд, элээ, хэрээ, тас, шар шувуу болжмор ууль, тагтаа зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, хонин гүрвэл, шавьж болон жижиг далавчтанаас голио, царцаа

зөгий зэрэг байдаг.

Тусгай хамгаалалттай газар болох Алтайн таван богд, Сийлхэмийн нурууны “А” бүсэд аргаль, янгир, тарвага элбэг.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 32 аж ахуйн нэгж, 71685 га талбайд жонш, нүүрс, өнгөт металл, төмөр, уран, цемент зэрэг ашигт малтмалын төрлүүдээр тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Орон нутгийн тусгай хамгаалалттай сумын тусгай хамгаалалттай зэрэг үзэсгэлэнт газартай. Тус сум нь 17 булаг, 123 худаг устай. Сүүлийн жилүүдэд төсөл хөтөлбөрөөр болон өөрсдийн санхүүжилтээр 76 га бэлчээр хашиж, 3 га газарт мод, сөөг тариад байна.

Байгаль орчны SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
------------------	----------------

<ul style="list-style-type: none"> • Байгалийн баялаг элбэгтэй • Байгалийн баялаг ашигласнаар санхүүгийн эх үүсвэр нэмэгдэнэ • Төсөл хөтөлбөрөөр бэлчээр, ногоон байгууламж нэмэгдсэн • Газар нутгийн ихэнх хэсгийг тусгай хамгаалалтанд авсан • Хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлагдсаныг сумын тусгай хамгаалалтанд авсан • Байгалийн үзэсгэлэнт газар элбэгтэй • Малчны бүлгүүдэд бэлчээрийг хариуцуулсан • Уул уурхайн компаниудаас орон нутагт орох хөрөнгө нэмэгдсэн • Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж эзэмшүүлж, ашиглуулсан 	<ul style="list-style-type: none"> • Иргэд хуулийн хүрээнд ашигт малтмал ашиглах, санал санаачлага муу • Хариуцлагагүй уул уурхайгаас нөхөн сэргээлт хийгдээгүй • Ундны усны чанар муу • Хог зөөврийн унаа байхгүй • Нэгдсэн халаалтын системгүйгээс агаарын бохирдол их • Мэдээлэл сургалт сурталчилгаа дутмаг • Бэлчээрийн доройтол ихэссэн • Байгаль орчны мэргэжилтнүүд техник тоног төхөөрөмжөөр дутмаг
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Ногоон байгууламж нэмэгдүүлэх /иргэн, өрх, бүлэг хоршоо, байгууллага, ААН/ • Уул уурхайг түшиглэн ажилгүйдлийг бууруулах • Төсөл хөтөлбөрт хамрагдан бэлчээр хаших • Ундны усны чанарыг сайжруулах • Бичил уурхайг эрхлэх • Байгаль хамгаалагч, идэвхтэн байгалив хамгаалагч, иргэд, 	<ul style="list-style-type: none"> • Зам харилцаа муугаас тоосжилт их, бэлчээр доройтсон • Байгалийн гамшгийн давтамж ойр • Уул уурхайн компаниудын хариуцлагагүй байдал

2.1. Иргэд, оролцогч талуудын оролцооны үнэлгээний дүн

Оролцогч талуудын оролцооны дүн

№	Оролцооны үнэлгээ	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Фокус бүлгийн судалгаа	8	
2	БОС	1	50
3	SWOT шинжилгээ	17	17
4	Олон нийтийн хэлэлцүүлэг	11	666
5	Санал асуулгын хуудас	7	267
6	Сумын чадавхийн үнэлгээ	1	100
7	Ганцаарчилсан ярилцлага	9	13
8	Мэдээллийн самбар	8	12
9	ЕБС-ийн зохион бичлэг	1	34

10	ИТХ-ын төлөөлөгч сонгогчидтой уулзах	1	24
11	Багийн засаг дарга айл өрхөөр явж санал авах	5	53
12	Саналын хайрцаг	3	3
13	Гар зургийн уралдаан	1	79
Д Ү Н		73	1375

Иргэд, оролцогч талуудын оролцооны үнэлгээний дүн

2.1.1. Бизнес орчны судалгааны дүгнэлтүүд

Бизнесийн орчны судалгаа явуулах, түүний үр дүнг сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн

олон жилийн статистик, үзүүлэлтүүдээр баталгаажуулах нь сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин, өрсөлдөх чадвар, хэтийн төлөв, тулгамдаж байгаа асуудлыг үндэслэл, баримжаасайтай тодруулах боломжтой арга хэрэгсэл юм.

Бизнесийн орчин судалгааны хүрээнд 50 бизнес эрхлэгчдээс санал асуулгыг 4 бүлэгт хамаарах 25 асуудлаар явуулснаас гадна сумын эдийн засгийн үндсэн статистик үзүүлэлтүүд болон бусад

мэдээллийг сүүлийн 5 жилийг хамруулан цуглуулж дүн шинжилгээ хийлээ. Бизнесийн орчны

судалгааны дүнг СВОТ шинжилгээ хийх, бизнес орчны талаар сумын эдийн засгийн хөгжлийн

хөтөлбөрт тусгагдах гол үндэслэл, дүгнэлтүүдийг томъёолох суурь материал болгон ашиглав.

Бизнес орчны судалгааны нэгтгэлийн үр дүнгээс бизнесийн ирээдүйгээ өөдрөг гэж судалгаанд

оролцогчдын 88.2%, бизнесээ өргөтгөх бодолтой гэж 91.2% нь хариулсан нь тус суманд одоо байгаа бизнесийг өргөжүүлэн хөгжүүлэх боломж байна гэж дүгнэж байна. Харин бизнесийг өргөтгөх ямарарга зам байгааг судалгаанд оролцогчдын 35% нь үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ гэсэн нь зөв хандлага

бөгөөд 21% нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, зах зээлээ өргөтгөх талаар дурдсан байна.

Харин 23% нь хэмжээг нь нэмэгдүүлэх гэсэн нь хэвийн үзэгдэл юм.

Эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэхэд нутгийн захиргааны зүгээс одоо гүйцэтгэж байгаа үүргийг хувийн хэвшлийнхний үнэлгээнд тулгуурлан тодорхойлоход төрийн үйлчилгээг бэхжүүлэх явдал хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд төр, захиргааны шуурхай ажиллагааг хангах явдал дараагийн шийдэх ёстой чухал алхам болж байна. Мөн дэдбүгцийг сайжруулах, байгаль хамгаалах, газар, ажлын байр олгох асуудлыг хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаж өгөх шаардлага гарч байна.

Свот шинжилгээний матриц, дүгнэлтүүд

Бизнес орчны судалгааны дүнг задлан шинжлэх, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, бизнесийн орчныг

сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, стратегийн чиглэлүүдийг тогтоох зорилгоор СВОТ шинжилгээ явуулав.

Сумын хөгжилд тулгарч байгаа гол асуудлуудыг тодорхойлж, эерэг болон сөргөөр илэрч болох бүх талууд, тэдгээрийн зохистой шийдлийг хослолоор зэрэгцүүлэн томъёолоход СВОТ шинжилгээний зорилго, хандлага чиглэгдсэн юм. Ингэснээр бид төсөөлөн байгаа зорилгодоо хүрэх хамгийн зохистой, хэрэгжих хувилбарыг сонгох болон сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөгдээр дурдсан хандлагад тулгуурлан боловсруулах үндэслэлийг тодорхойллоо.

Сумын эдийн засгийн хөгжил, бизнес орчны өнөөгийн түвшинг үнэлэх, цаашдын хөгжлийн стратегийн гол шийдлийг СВОТ шинжилгээг ашиглаж тогтоосон болно. СВОТ шинжилгээний үрдүн нь сумын нийгэм, эдийн засгийг 2024 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөний алсынхараа, зорилго, зорилтыг томъёолж, төслүүдийг сонгоход нэн чухал суурь мэдээлэл болж өгсөн гэж дүгнэж байна.

Гуравдугаар бүлэг: СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Хөгжлийн алсын хараа, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл

АЛСЫН ХАРАА

СУМЫН ИРГЭДИЙН НИЙТЛЭГ ЭРХ АШГИЙГ ДЭЭДЛЭН, ХҮН, ӨРХ ГЭРИЙН ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭЖ, БАЯЛАГИЙГ БҮТЭЭГЧ, ЭРХ ЧӨЛӨӨТ, АЖИЛ ОРЛОГОТОЙ ИРГЭД БҮХИЙ БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ НОГООН ЭДИЙН ЗАСАГТАЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛААР БҮСДЭЭ ТЭРГҮҮЛСЭН СУМ БОЛНО

Сумын хөгжилд, тэргүүлэх чиглэл:

1. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

Мал аж ахуй, газар тариалангийн салбарыг сумын эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон эрчимжүүлэн хөгжүүлнэ. Уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ малын үүлдэр угсааг сайжруулах, өндөр ашиг шим бүхий үржлийн малтай болоход илүүтэй анхаарна. Газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөтгөн усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

Орон нутгийн нөөц, зах зээлийн эрэлт хэрэгцээний шаардлагад тохирсон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг чухалчилна.

3. АЯЛАЛ ЖУЛЧЛАЛ

Байгалийн үзэсгэлэнт газруудыг ашиглан иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхийг эрхэмлэнэ.

Төлөвлөгөөний хүрээний зорилго, зорилт, хөтөлбөрүүд

Улаанхус сумын хөгжлийн стратегийн зорилго, зорилтын нэгдсэн матриц

Ерөнхий зорилгууд		Зорилтууд
Зорилго-1 Уламжлалт болон эрчимжсэн, мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, орон нутгийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл үйлчилгээний хөгжлийг түргэтгэн иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлнэ.	Зорилт 1.1	Мал аж ахуйн салбарын хөгжлийг түргэтгэх
	Зорилт 1.2.	Газар тариаланг хөгжүүлэх
	Зорилт 1.3	Орон нутгийн онцлогт тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж ажлын байраар хангаж иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ
Зорилго-2 Бизнес эрхлэх аюулгүй, таатай орчныг бүрдүүлнэ.	Зорилт 2.1	Замын тээвэр, эрчим хүч, холбоо мэдээлэл, худалдаа үйлчилгээ, инженерийн төвлөрсөн байгууламжийг шинээр бий болгон үйлчилгээг тогтмолжуулна.
	Зорилт 2.2	Дэвшилтэт тоног төхөөрөмжийг нэвтрүүлэн бизнесийн орчин нөхцөлийг сайжруулна.
Зорилго-3 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж эрүүл, оюунлаг иргэдийг төлөвшүүлнэ.	Зорилт 3.1	Боловсролын салбарын чанар хүртээмжийг сайжруулна.
	Зорилт 3.2	Соёлын үйлчилгээг тогтмолжуулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
	Зорилт 3.3	Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
	Зорилт 3.4.	Хүн амын өсөлтийг хангаж, иргэдийн эрүүл аюулгүй амьдрах таатай орчинг бүрдүүлэн өрхийн амьжиргааг дээшлүүлнэ
Зорилго-4 Экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, хамгаалж, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	Зорилт 4.1.	Экологийн тэнцвэрт байдлыг хангаж, байгаль орчны доройтлыг бууруулна.
	Зорилт 4.2.	Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ
	Зорилт 4.3.	Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ

3.2.Сумын хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хангах хүрээнд хамрах хөтөлбөр, төслүүд

Зорилго, зорилтуудыг хангах хүрээнд хамрах хөтөлбөр, төслүүд

№	Хөтөлбөр	ДҮД	Код	Хэрэгжүүлэх төслүүд
Зорилго 1. Уламжлалт мал аж ахуйг эрчимжсэн аж ахуйтай хослуулан орон нутгийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийг түргэтгэн иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлнэ				
Зорилт 1.1 Мал сүргийн зохистой бүтцийг бий болгон тогтвортой өсөлтийг хангана				
1	1.1.1 Малын удмын санг хамгаалж, МАА-н үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх,	1	1.1.1.1	Хонийг "керей" үүлдэрээр, ямааг уулын бор ухна авч сайжруулагчаар ашиглах
		2	1.1.1.2	Үхрийг мах, сүүний чиглэлээр сайжруулах
		3	1.1.1.3	Адууны үүлдэр угсааг сайжруулах
		4	1.1.1.4	Эрчимжсэн фермерийн үхрийн аж ахуйг 2-оос доошгүйг хөгжүүлэх
		5	1.1.1.5	Сүүний чиглэлийн үхрийн фермерийг 1-ээс доошгүйг хөгжүүлэх
		6	1.1.1.6	Сумын нийт мал сүргийг бүртгэлжүүлж мэдээлэлийн сан бүрдүүлэх
		7	1.1.1.7	Цөм сүрэг жишигт тэнцсэн хээлтүүлэгчийг удам гарвал, ашиг шим эрүүл мэндийн үзүүлэлтээр мэдээлэлийн сан бүрдүүлэх
		8	1.1.1.8	Зохиомол хээлтүүлгийн явуулын пункттэй болох
Зорилт 1.2 Бэлчээрийн даацыг сайжруулан, газар тариалан эрхлэлт ийг нэмэгдүүлнэ				
2	1.1.2 Мал сүргийн зохистой харьцааг хангасан сүргийн бүтэц бий болгон малын өсөлтийг тогтвортой хангах	9	1.1.2.1	Мал сүргийг бэлчээрийн даацанд тохируулан таван төрлөөр өсгөж, тэнцвэртэй зохистой харьцааг бий болгох
		10	1.1.2.2	Малчдыг мэрэгжлийн сургалтанд хамруулах
		11	1.1.2.3	Тэмээн сүргийг өсгөх
3	1.1.3 Мал эмнэлгийн ажил үйлчилгээг нийгмийн шаардлагад нийцүүлэн, эрэлт хэрэгцээг бүрэн хангах	12		Мал эмнэлгийн тусгай зориулалтын байртай болох
		13	1.1.3.1	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чадавхийг сайжруулахад орчин үеийн тоног төхөөрөмжтэй лаборатортой болох
		14	1.1.3.2	Мал эмнэлгийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах
		15	1.1.3.3	Мал эмнэлгийн үйлчилгээнд мал сүргийг бүрэн хамруулж, малыг эрүүлжүүлж, халдваргүйжүүлэх
		16	1.1.3.4	Малын эмийн эргэлтийн санг бэхжүүлж , стандартын шаардлага хангасан эм, эм бэлдмэлээр хангах
4	1.2.1 Бэлчээрийн менежментийг сайжруулах	17	1.2.1.1	Малчны бүлэгт хамрагдаагүй малчдыг бүлэг болгон, бэлчээрийг хариуцуулах
		18	1.2.1.2	Сумын отрын бүс нутаг бий болгох

		19	1.2.1.3	Тэжээлийн олон наст ургамлыг жил бүр 1-га-гаас доошгүй талбайд тариалах
		20	1.2.1.4	Сумын хэмжээнд тэжээл үйлдвэрлэх жижиг цех байгуулах
		21	1.2.1.6	Сумын хэмжээний өвс тэжээлийн фондтой болох
5	1.2.2 Хүлэмжийн аж ахуй, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж сумын хэрэгцээг хангах	22	1.2.2.1	Суманд 2-оос доошгүй хүлэмжийн аж ахуйг бий болгох
		23	1.2.2.2	5-аас доошгүй га-д төмс хүнсний ногоо тариалах
		24	1.2.2.3	Усалгааны дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх
		25	1.2.2.4	Чацарганыг жилд 0.5 га газарт тариалах

Зорилт 1.3 ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлнэ

6	1.3.1 Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх	26	1.3.1.1	Гэр ахуйн цахилгаан бараа, төрөл бүрийн техник хэрэгслийн засвар үйлчилгээ
		27	1.3.1.2	Угаалга хими цэвэрлэгээ
		28	1.3.1.3	Интернет кафе
		29	1.3.1.4	Үсчин, гоо сайхан
		30	1.3.1.5	Зурагчин
		31	1.3.1.6	Гутал засвар
		32	1.3.1.7	Оёдол
		33	1.3.1.8	Авто засвар
		34	1.3.1.9	Казах үндэсний гар урлал
7	1.3.2 Үйлдвэрлэлийг хөгжүүлэх	35	1.3.2.1	Арьс ширний боловсруулах цех
		36	1.3.2.2	Барилгын материалын үйлдвэрлэл
		37	1.3.2.3	Эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэх цех
		38	1.3.2.4	Модон эдлэлийн цех
		39	1.3.2.5	Талх нарийн боовны цех
		40	1.3.2.6	Сүү боловсруулах цех
		41		Цэвэр усны үйлдвэрлэх цех
		42		Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех
43	1.3.2.7	ХАА-н хоршоог байгуулах		
8	1.3.3 Туслах аж ахуйг хөгжүүлэх	44	1.3.3.1	Тахианы аж ахуй
		45	1.3.3.2	

Зорилго-2: Иргэдийн ажиллаж амьдрах, бизнес эрхлэх аюулгүй таатай орчныг бүрдүүлнэ

Зорилт 2.1 Бүтээн байгуулалтаар тохилог орчинг бүрдүүлнэ

	2.1.1 Ажлын ба орон байрны хангамжыг сайжруулах	46	2.1.1.1	Нутгийн удирдлагын ордон барих
		47	2.1.1.2	Өлгий -Улаанхус чиглэлийн 50 км-ын сайжруулсан замтай болох
		48	2.1.1.3	Сумын төвд 2 км-т хатуу хучилттай зам тавих

9		49	2.1.1.4	ЦДАШ-ын ойролцоох 5-аас доошгүй хот айлд бууруулах трансформатар тавьж төвлөрсөн эрчим хүчинд холбох
		50	2.1.1.5	Согоог голд бетон гүүр бариулах
		51	2.1.1.6	Байгууллага аж ахуйн нэгж, айл өрхийг цэвэр бохир ус, халаалтын нэгдсэн сүлжээнд холбох
		52	2.1.1.7	Худалдааны нэгдсэн төвтэй болох
		53	2.1.1.8	500 хүний суудалтай соёлын төвийн барилга барих
		54		Хөххөтөл багт 240 хүүхдийн сургуулийн барилга барих
		55		Хөх хөтөл багт 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих
		56		Согоог багт 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих
		57	2.1.1.9	Согоог багт 240 хүүхдийн хичээлийн барилга барих
10		58	2.1.1.10	Хөхөтөл,Согоог сургуульд хүүхдийн дотуур байрны барилга барих
		59	2.1.1.11	200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих
		60	2.1.1.12	ХАА мал эмнэлэг, үржлийн албаны , сургалт шинжилгээний нэгдсэн лабораторын барилга барих
		61	2.1.1.13	Саун бүхий нийтийн халуун ус барих
		62	2.1.1.14	Зочид буудал барих
		63	2.1.1.15	40 айлын орон сууц барих
		64	2.1.1.16	Аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтын барилга байгууламж барих
		65	2.1.1.17	Сумын төвийн хөгжлийн срөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах
		66	2.1.1.18	ААН, байгууллага, гудамж хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох
		67	2.1.1.19	Хог зөөврийн унаатай болж хогийн цэгийг хашаажуулах
		68	2.1.1.20	Хог ангилан ялгах, боловсруулах цэг байгуулах
		69	2.1.1.21	Малчин өрхүүдийг сэргээгдэх эрчим хүчээр 100% хангах
		70		Согоогийн услалтын системд 10 кв ЦДАШ, дэд станц тавих
		71	2.1.1.22	Багийн нэгдсэн төв барих
11	2.1.2 Орчны тохижилтыг сайжруулах	72	2.1.2.1	Сум, багуудын хоорондох автозамуудыг сайжруулах, Хөххөтөл багийн гүүрийг засварлах
		73	2.1.2.2	Сумын төвийн автозамыг хатуу хучилтай болгон тэмдэгжүүлэх
		74		Борбургасын голд гүүр барих

		75	2.1.2.3	Сумын төвийн ундны усны хангамжийг 2-оор нэмэгдүүлж , цэвэршүүлэх төхөөрөмж суурилууж, ариун цэврийн бүс тогтоох
		76	2.1.2.4	Залуучуудын ордон барих
		77	2.1.2.5	Байгууллага, ААН-үүдийн гадна орчны явган хүний зам талбайг тохижуулах
Зорилт 2.2 Дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн бизнесийн орчин нөхцлийг сайжруулна				
12	2.2.1 Мэдээлэл харилцаа холбооны хүртээмжийг нэмэгдүүлэх	78	2.2.1.1	Сумын веб сайтгыг тогтоомол ажиллуулах
		79	2.2.1.2	Үүрэн телефоны операторуудын тоог нэмэгдүүлэх
		80	2.2.1.3	FM радиогийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
		81	2.2.1.4	Орон нутгийн телевизтэй болох
		82	2.2.1.5	Орон нутгийн сонинтой болох
		83	2.2.1.6	Төрийн үйлчилгээнд нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх
	2.2.2 Банк санхүү, татварын тогтолцоог сайжруулах	84	2.2.2.1	Арилжааны банкуудад төлбөрийн карт, интернэт, мобайл зэрэг бэлэн бус төлбөрийн тооцооны хэлбэрүүдийг нэвтрүүлэх
		85	2.2.2.2	Банкуудын төлбөр тооцоонд шинэлэг үйлчилгээг , бэлэн мөнгөний АТМ-ийн үйлчилгээг нэвтрүүлнэ .
Зорилго-3 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж эрүүл, оюунлаг иргэдийг төлөвшүүлнэ				
Зорилт 3.1.Боловсролын салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна				
13	3.1.1. СӨБ-ийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, сурч хөгжих материаллаг орчин нөхцөлийг сайжруулах	86	3.1.1.1	СӨБ-ын үйлчилгээний машинтай болох
		87	3.1.1.2	Гэр цэцэрлэгтүүдийг байнга ажиллуулах
		88	3.1.1.3	Тоглоомын хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх
		89	3.1.1.4	Багшийн хөгжлийн төвийг шинээр барьж тохижуулах
		90	3.1.1.5	Урлаг, спортын танхимыг тоног төхөөрөмжөөр бүрэн хангах ,
		91	3.1.1.6	Гал тогооны цахилгаан тоног төхөөрөмжийг шинээр тавих
		92	3.1.1.7	Багш ажилчдын алжаал тайлах, чийрэгжүүлэлтийн танхимтай болох
		93	3.1.1.8	0-2 насны хүүхдийг хүлээн авах яслийн бүлэг нээх
14	3.1.2 ЕБС-ийн сургалтын орчинг сайжруулна.	94	3.1.2.1	Багш хөгжлийн төвийг шинээр барьж тохижуулах
		95	3.1.2.2	Цахим номын сантай болж, номын фондыг нэмэгдүүлнэ.
		97	3.1.2.4	Мэдээлэл технологийн танхимыг тохижуулах
		98	3.1.2.5	Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж нэмэгдүүлэх

		100	3.1.2.7	Мэргэжлийн хичээлүүдийн кабинет тохижуулах
Зорилт 3.2 Соёлын үйлчилгээг тогтмолжуулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ				
15	3.2.1 Соёлын үйлчилгээ явуулах таатай орчин нөхцлийг сайжруулна	101	3.2.1.1	Техник хэрэгслээр хангах
		102	3.2.1.2	Хөгжмийн зэмсэгээр хангах
		103	3.2.1.3	Урлагийн хувцсаар хангах
		104	3.2.1.4	Соёлын төвийг шинээр барих 500 хүний
		105	3.2.1.5	Номын худалдааны цэг байгуулах
16	3.2.2 Түүх өв соёлоо хадгалан хамгаалж, соёл урлагын үйл ажиллагааг чанар хүртээмжтэй, хүргэх	106	3.2.2.1	Явуулын иж бүрэн тоноглогдсон машинтай болох
		107	3.2.2.2	Орон нутгийг судлах танхим байгуулах
Зорилт 3.3 Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулна				
17	3.3.1 Дотоод орчныг тохижуулах	108	3.3.1.1	Гал тогоог тоног төхөөрөмжөөр бүрэн хангах
		109		Эмнэлгийн барилгад өргөтөгөл хийх
		110	3.3.1.2	Сургалтын өрөөг техник тоног төхөөрөмжөөр хангах
18	3.3.2 Эмнэлгийн үйлчилгээний нэр төрөл нэмэгдүүлэх	111	3.3.2.1	Иж бүрэн тоноглогдсон түргэний машинтай болох
		112	3.3.2.2	Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх
		113	3.3.2.3	Эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх
		114	3.3.2.4	Лабораторийн шинжилгээний багаж төхөөрөмжийг нэмэгдүүлэх
		115	3.3.2.5	Алсын зайны оношлогоо эмчилгээний аргуудыг эрүүл мэндийн төвдөө нэвтрүүлэх
		116	3.3.2.6	Багийн эмч нарыг унаажуулах
		117	3.3.2.7	Нөхөн сэргээх асаргаа сувилгааны танхимтай болгох
		118	3.3.2.8	Сэтгэлзүйч эмчтэй болж кабинет байгуулах
		119	3.3.2.9	Уламжлалт эмчилгээний танхимтай болох
		120	3.3.2.10	Шүдний эмч, кабинеттэй болох
		121	3.3.2.11	Чийрэгжүүлэлтийн кабинетийг шинээр барих
Зорилт 3.4 Хүн амын өсөлтийг хангаж,иргэдийн эрүүл аюулгүй амьдрах таатай орчинг бүрдүүлэн өрхийн амьжиргааг дээшлүүлнэ				
19	3.4.1 Иргэдийг ажлын байраар хангаж өрхийн орлогыг нэмэгдүүлэх	122	3.4.1.1	Ажилгүй иргэдийг ажлын байраар хангах
		123	3.4.1.2	Сумд шаардлагатай мэргэжлээр МСҮТ-д сурган мэргэжилтэй болгох
		124	3.4.1.3	Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх
20	3.4.2 Нийтийн биений тамир спортыг хүн амын дунд хэвшил болгож эрүүл аж төрөх ёсыг	125	3.4.2.1	Ахмадуудын чийрэгжүүлэлтийн танхимтай болох

	төлөвшүүлэх	126	3.4.2.2	Урлаг спортын алдартнуудын уралдаан тэмцээнийг тогтмолжуулах
		127	3.4.2.3	Сумын хэмжээнд "Үш- арыс хүчтэн бөхийн дэвжээ байгуулах
		128	3.4.2.4	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах
Зорилт 3.5 Суманд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтыг бууруулна				
21	3.5.1 Сургалт сурталчилгааг тогтмолжуулах	129	3.5.1.1	Сургалт сурталчилгаа явуулах хууль эрх зүйн мэдээллийн танхимтай болох
22	3.5.2 Олон нийт цагдаа хамтын ажиллагааг сайжруулах	130	3.5.2.1	Сумын төвийг камержуулах
		131	3.5.2.2	ААН, байгууллагуудыг дохиолол, камерийн системд холбох
		132	3.5.2.3	Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг, нөхөрлөлтэй болж сан байгуулах
		133	3.5.2.4	Бод малд индексжүүлсэн бүртгэл буюу ЧИП суулгах
Зорилго-4: Экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалж, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ				
Зорилт 4.1 Экологийн тэнцвэрт байдлыг хадгална				
23	4.1.1 Цөлжилтийг сааруулж, ногоон байууламжийг нэмэгдүүлэх	134	4.1.1.1	Сумын төвийн агаарын бохирдолыг бууруулах
		135	4.1.1.2	Ногоон зурвас бий болгох, цэцэрлэгжүүлэх
		136	4.1.1.3	Хортон мэрэгчидийг багасгах
24	4.1.2 Усан хангамжийг нэмэгдүүлж агаар бохирдлыг бууруулах	137	4.1.2.1	Жилд гүн өрмийн худаг 1, энгийн уурхайн худаг 1 гаргах
		138	4.1.2.2	Худаг, уст цэг засварлах /жилд 2-оос доошгүй/
		139	4.1.2.3	Булаг шандны эхийг хашиж урсацыг сайжруулах / 17 булаг /
		140	4.1.2.4	Гүний усны хайгуул хийх /10-аас доошгүй/
		141	4.1.2.5	Агаар болон хөрсний бохирдолын шинжилгээний багажтай болох
25	4.1.3 Түгээмэл тархацтай байгалийн баялагийг зөв зохистой ашиглаж хамгаалах	144	4.1.3.1	Хайрга, чулуу, элс, шаварыг тогтоосон цэгээс олборлож, нөхөн сэргээлтийг хийх
		145	4.1.3.2	Хужир, зосыг тогтсон цэгээс ашиглуулах
Зорилт 4.2 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх				
26	4.2.1 Нөхөн сэргээх	146	4.2.1.1	Сумын төвийн ундны усны эх үүсвэрүүдийг цэвэршүүлэх гүний худагтай болох.
		147	4.2.1.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН нь жил бүр биологийн нөхөн сэргээлтийг талбайнхаа 5-аас доошгүй хувьд хийх
27	4.2.2 Байгаль хамгаалах тасаг байгуулах	148	4.2.1.3	Үйл ажиллагаа явуулж буй ААН, нөхөрлөлүүдийн талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийлгэж, уурхайн орчныг

			байнгын усалгаатай болгох	
	149	4.2.2.1	Байгаль хамгаалах төрийн бус байгууллага. Сайн дурын бүлгүүдийг үүсгэж чадваржуулах	
	150	4.2.2.2	Байгаль хамгаалах бүлэг машин, техник хэрэгслээр хангах	
	151	4.2.2.3	Хөрөнгө оруулагчдын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах	
Зорилт 4.3 Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ				
28	4.3.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх	152	4.3.1.1	Орон нутгийн үзэсгэлэнт газруудын тойрон аялах маршрутыг гаргаж хөтөчтэй болох
		153	4.3.1.2	Орон нутгийн үзэсгэлэнт газруудыг сурталчилах
		154	4.3.1.3	Алтайн таван богд, сийлхэмийн нурууны хамгаалалтын менежментийн төлөвлөгөө гаргах
29	4.3.2 Зэрлэг ан амьтан хамгаалах сан байгуулах	155	4.3.2.1	Ган, зудтай үед ховордсон ан амьтадад өвс, хужир тавьж өгөх
		156	4.3.2.2	Ирвэс, Аргаль, Янгир болон суурьших боломжтой ан амьтдыг нутагшуулах
		157	4.3.2.3	Ховордсон ан амьтад дохиоллын системийг суулгах
		158	4.3.2.4	Ховордсон ургамлын зүйл ангийг нэмэгдүүлж тариалах

3.3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг

Оролцогч талууд	Оролцох үндэслэл	Ашиг сонирхол	Нөлөөний түвшин
Иргэд	Тэд санаа гаргаж, төлөвлөж, хэрэгжүүлэхэд оролцож, үр дүнг хянаж байх	Төлөвлөгөөг иж бүрэн хэрэгжүүлж үр ашгийг хүртэх	
Бизнес, аж ахуйн хэвшлийнхэн	Бизнес, аж ахуйн нэгжүүд нь байгууллагын хувьд төлөвлөлтөнд өөрсдийн хөгжлийн чиг хандлагыг тусгах, хэрэгжүүлэхэд зарим хэмжээний хөрөнгө оруулах замаар үр дүнг дээшлүүлэх	Сумын төлөвлөгөөний хэрэгжилтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, орон нутгийн нөөцөд тулгуурлан өөрсдийн бизнесийг өргөтгөх	
Иргэний нийгэм,	Олон нийт, гишүүдийн санааг илэрхийлэх, төлөвлөгөөний хүрээний	Төлөвлөгөөний биелэлтийг	

Төрийн бус байгууллагууд	арга хэмжээнүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, шудрага байхад чиглэсэн дуу хоолой гаргаж байх	хангахад өргөн оролцоог хангах, нийтлэг эрх ашгийг хамгаалж, дуу хоолой илэрхийлэх
Сумын төрийн байгууллага	Төлөвлөгөөг эцэслэн батлах, хэрэгжилтийг зохион байгуулах гол үүрэг, хариуцлагыг хүлээх, биелэлтийг хянах	Төлөвлөгөөг зохиох, хэрэгжүүлэхүйл ажиллагааг удирдан зохицуулах, сумын хөгжлийг хангах, нэр хүндтэй болох
Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр, ханди влагч хөрөнгө оруулагчид	Хөгжилд дэмжлэг үзүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Дэмжлэг, хөрөнгө оруулалтынашиг үр дүн
Сумын төлөвлөлт, хяналтын хороо	Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох үүрэгтэй	Төлөвлөгөөний бодит байдлыг хангах, хянах, зохицуулалт хийх асуудлыг шуурхай зохион байгуулах, олон нийтийн төлөөллийн оролцоог хангах
Нутгийн зөвлөл	Хөгжилд дэмжлэг үзүүлэх, сурталчлахад оролцох	Арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН АСУУДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2014-2024 оны сумын хөгжлийн цогцолбор төлөвлөгөөг боловсруулав.

Төслийн танилцуулга, төслийн хяналт үнэлгээ, төслийн товчоогоор багцлан дүгнэж 2014 оны зах зээлийн үнэлгээр тооцон гаргахад **38227** сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байгаа бөгөөд энэхүү санхүүгийн асуудлыг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр урьдчилан тооцоолж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр **24,36** хувь буюу **9313** сая төгрөг
- Улсын төсвийн хөрөнгөөр **68,59** хувь буюу **26220** сая төгрөг
- Хандив, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр **5,54** хувь буюу **2120** сая төгрөг

Дөрөвдүгээр бүлэг. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

4.1. Гол үр дүнгийн шалгуур үзүүлэлт

4.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн нэгдсэн шалгуур үзүүлэлтүүд

Сумын хөгжлийн төлөвлөгөөний үр дүнг тооцохдоо дараах ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэл болгож байна. Үүнд:

ДД	Гол үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоогийн түвшин	Хүрэх түвшин		
1.	Нэг хүнд ноогдох ДНБ	Мян.төг	1700	5000	10000	15000
2.	Сумын хүн ам	Тоо	7600	8500	9200	11400
3.	Сургуулийн суралцагчдын сурлагын амжилт	Хувь	63,6	67	70	75
4.	Сургуулийн мэргэжлийн зэрэгтэй багшийн хувийн жин	Хувь	52,9	76,4	88,2	95
5.	Бичиг үсэг үл мэдэгч	Тоо	20	15	30	-
6.	Сургуулийн өмнөх боловсролын стандарт хангалт	Хувь	67	75	80	85
7.	СӨБ-ын хамран сургалт	Хувь	82	92	97	100
8.	СӨБ-ын мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувийн жин	Хувь	33,3	66,6	88	95
9.	Соёлын мэргэжлийн боловсон хүчний хангалт	Хувь	80	100	100	100
10.	Соёл, урлагийн явуулын үйлчилгээний тоо	Тоо	6	9	12	15
11.	Соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо	Мянган хүн	8	9	10,5	12
12.	Соёл, урлагийн чиг баримжаат дугуйлан	Тоо	1	4	8	8
13.	Хүн амын өвчлөлийн түвшин	Хувь	28,2	19,6	17,1	13,9
14.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт	Хувь	26,2	45	60	80
15.	Нэг цонхны ба явуулын үйлчилгээнд хамрагдсад	Мянган хүн	0	3	4	5
16.	Эрх зүйн төвөөр үйлчлүүлэгчдийн тоо	Мянган хүн	0	0,5	1	1,5
17.	Төрийн үйлчилгээний ажлын тайлан тавилтанд хамрагдагчид	Мянган хүн	1.2	2	3	4
18.	Ажилгүйдлийн түвшин	Хувь	1,9	1,5	1,3	0.5
19.	Ядуурлын түвшин	Хувь	57	29	13	4
20.	Нийгэм зүй, амьдрах ухааны сургалтанд хамрагдагчид	Хүний тоо	150	399	500	800
21.	Сайжруулсан ба хатуу хучилттай зам	Км	0	0	30	121
22.	Инженерийн хийцтэй гүүр	Тоо	0	2	3	4
23.	Цахилгаан эрчим хүчний хангамжтай өрх	Хувь	87	95	100	100
24.	Үүрэн телефон хэрэглэгчид	Тоо	1600	2700	3850	6600
25.	Бизнес эрхлэгчид (малчид ороогүй)	Хүний тоо	60	80	100	130
26.	Мэдлэг, чадвартай бизнес эрхлэгчид	Тоо	50	100	120	130

27.	Бизнесийг дэмжих болон эрх зүйн үйлчилгээ үзүүлэгч цэгийн	Тоо	0	1	1	1
28.	Гадаал харилцаанд оролцох чиглэл	Тоо	0	3	5	6
29.	Сумын өөрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага	Тоо	0	1	2	2
30.	Малын тоо	Толгой	158000	180000	200000	250000
31.	Тэмээний тоо	Толгой				
32.	Нэг ямаанаас авах ноолуур	Гр	300	310	330	350
33.	Тэмээний нэгдүгээр зэргийн ноос	Кг	5	5,1	5,3	5,5
34.	Хонины нэгдүгээр зэргийн ноос	Кг	1,2	1,3	1,4	1,5
35.	Хүлэмжийн тоо	Тоо	4	5	8	10
36.	Чацарганы тариалалтын талбай	Га	1	15	20	25
37.	Жижиг, дунд үйлдвэр	Тоо	4	6	12	19
38.	Аялал, жуулчлалын баазын тоо	Тоо	1	2	3	4
39.	Аялал, жуулчлалын үйлчилгээ авагчид	Тоо	800	2400	3900	5000
40.	Эрэлтэнд нийцсэн худалдаа, үйлчилгээний томоохон цэг	Тоо	0	1	2	3
41.	Бараа борлуулалтын нийт орлого	Сая.төг	400	800	1650	1850
42.	Ашиглагдахгүй байгаа бэлчээр	Га	265	175	100	50
43.	Таримал ойн зурвас	Га	1	16	40	62
44.	Инженерийн хийцтэй худгийн тоо	Тоо	17	20	23	25
45.	Хог бүхий талбайн хэмжээ	Га	5	4	3	2
46.	Хадлангийн хашсан талбай	Га	2	8	15	20

4.2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт

Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол улсын хуулийнхүрээнд хөгжлийн тухай баримт бичиг, нийгэм, эдийн засгийн хөгжлийн жил, жилийнчиглэл, төсвийн талаарх эрх зүйн акт, бусад хууль тогтоомж, холбогдогчидтой байгуулсангэрээ, хэлцлийн дагуу зохион байгуулагдана.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгайлан боловсруулсанбөгөөд цаашдын үйл ажиллагааг төлөвлөгөөний биелэлтийн явц, тухайн үед үүссэн нөхцөлбайдалтай уялдуулан жил, жилээр тодорхойлон хэрэгжүүлэх болно.

Төлөвлөгөөний хүрээнд сурталчилгаа мэдээлэл, олон нийттэй харилцах хамтран ажиллах үйл ажиллагаа

№	1. Сурталчлах үйл ажиллагаа	Зорилтот бүлэг	Давтамж	Үр дүн
1. СУРТАЛЧИЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
1.1	Олон нийтийн хурал цуглаан дээр хэтийн төлөвлөгөөг танилцуулах	Нийт иргэд	Эхний 5 жилд	Иргэд төлөвлөгөөний талаар ойлголттой

				болно.
1.2	Сумын хөгжлийн 2014-2024 оны төлөвлөнөөний хэрэгжилтийг олон нийтэд танилцуулж байх	Олон нийтэд	Жил бүр	Иргэдэд хэрэгжилтийн явц тодорхой харагдана.
1.3	Төлөвлөгөөг сумын нийт айл өрх, ААН, албан байгууллагад хэвлэж тараах	Айл өрх, ААН, Албан байгууллага	Жил бүр	Айл өрх, ААН, албан байгууллагууд төлөвлөгөөний талаар мэдээлэлтэй болно.
1.4	Сумын хөгжлийн 2012-2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийн самбар ажиллуулах	Малчин өрхүүд, малчдын дунд сурталчлахад эрхзүйн хөтөч нарыг ажиллуулах	Малчин өрх	Ил тод нээлттэй, хэрэгжилтийн явц тодорхой, олон түмэнд хүртээлтэй
1.5	Малчин өрхүүд, малчдын дунд сурталчилахад эрхзүйн хөтөч нарыг ажиллуулах	Малчин өрх	Байнга	Малчин иргэд мэдээлэлээр хангагдана.
2. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
2.1	Нутгийн төрх сонинд нийтлүүлэх		Улирал бүр	Олон нийтэд таниулна
2.2	Орон нутгийн FM-р мэдээлэл хүргэж байх	Олон нийтэд	Тогтмол	Иргэд мэдээлэл байнга авч байна.
2.3	Сумын вэб хуудсанд тавьж олон нийтэд ил тод болгох	Хөрөнгө оруулагч бизнес эрхлэгчдэд	Жил бүр	Хөрөнгө оруулагч сонирхсон иргэд мэдээлэл авах боломж бүрдэнэ.
2.4	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах	ИНБ, Ахмад, Залуучууд, Эмэгтэйчүүд	Жилд	Бүх насны иргэдэд хүртээмжтэй болно.
2. ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
3.1	Нээлттэй хаалаганы өдөрлөгөөр иргэдэд танилцуулах, зөвлөгөө өгөх	Олон нийтэд	10-р сард	1
3.2	Иргэдээс судалгаа авах	Иргэд	жилд 1 удаа	Иргэдийн санал бодлыг мэдэж авна
3.3	Малчин иргэдээс санал асуулага авах, зөвлөх	Малчин өрх	жилд	Малчид зөв мэдээлэл авна.

Тавдугаар бүлэг: ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Ерөнхий зүйл :

Сумын хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж үнэлэх үйл явц нь сумын нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын үйл ажиллагаа болдог. Энэ үйл ажиллагааг сумын түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэгч нь төр захиргаа, иргэний нийгмийн төлөөлөл бүхий төлөвлөлт хяналтын хороо юм.

Хяналтыг голлон хэрэгжүүлэгч нь төлөвлөлт, хяналтын хорооны дарга, ажлын бүлгүүдийн ахлагч нар байна. Төлөвлөлт хяналтын хороо нь сумын хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулж эхлэх үйл явцаас төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусах хүртэлх үйл ажиллагааг явуулах бөгөөд төлөвлөгөөний хугацааг сунгах, хугацаа дуусмагч төлөвлөгөөг дахин боловсруулах үед үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна.

Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төлөвлөлт хяналтын хороо жил бүр хэлэлцэж, төлөвлөгөөний явцыг үнэлэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, хасах, тодотгох, байдлаар сайжруулж ажиллана. Хяналт тавих, үнэлгээ хийх явцаа хэрэгжүүлэхдээ заавал үнэлгээний багийг томилон ажиллуулна.

Төслийн хэрэгжилт, биелэлтийн явцад 1-2 удаа, төслийн хэрэгжилтийн үе шат бүрийн төгсгөлд сумын ИТХ, төлөвлөлт хяналтын хороо хяналт үнэлгээ хийнэ. Үнэлгээний үр дүн нь төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлтээр хэмжигдэнэ.

Мөн төрийн бус байгууллагууд, ард иргэд хяналт тавьж ажиллана. Төлөвлөлт хяналтын хорооны бүрэлдэхүүнд төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талууд болон эрх нь хөндөгдөх бүх нийтийн төлөөлөл заавал байна. Улс төрийн намуудтай хамтран ажиллах болно. Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төсөл хөтөлбөрүүдийн биелэлтийг үе шат бүрээр ард иргэдэд мэдээлж байгаа байдалд байнгын хяналт тавина.

5.1. Хяналтын хэлбэр ба байнгын байдлыг хангах зохион байгуулалт

Сумын хөгжлийн цогцолбор төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулж байгаа байдал,

хэрэгжилтийн явцад :

- Төрийн зүгээс
- Аймгийн төр, засгийн байгууллага,
- Сумын төр, засгийн байгууллага.
- Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд
- Сумын хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөлт, хяналтын хороо,
- Суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд,
- Иргэдийн үүсгэл, санаачлагаар байгуулагдсан бусад байгууллага, бүтцүүд,
- Сонирхсон бусад төрийн бус байгууллагууд.
- Орон нутгийн иргэд зохих хяналтыг тавьж ажиллана.

Сумд дээрх байгууллагуудын төлөөлөл оролцсон төлөвлөгөөний биелэлтийг хянах, ил тод

байдлыг хангаж мэдээлэх үүрэг бүхий хяналт, үнэлгээний багийг зохион байгуулж байна.

Хяналтын гол зорилго нь төлөвлөгөөний биелэлтийг хангуулахаас гадна, гарсан алдаа

зөрчлийг залруулах, тодорхой нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөөнд тодотгол, зохицуулалт хийх талаар санал дүгнэлт гаргахад чиглэгдэнэ.

Хяналт шинжилгээний ажил нь төлөвлөгөөний үе шат, цаг үеийн онцлогтой зохицсон аль болох байнгын тасралтгүй байх зарчмаар зохион байгуулна.

Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат, тайлагнах тогтолцоо

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд тодорхойлсон зорилтын хэрэгжилтийн явцад мониторинг хийж, үр дүнг үнэлэх үе шатууд:

- 1 дүгээр шат: Төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний үе шатны үнэлгээ (хугацаа 2015 оны 12 дугаар сар),
- 2 дугаар шат: Дунд үе шатны үнэлгээ (хугацаа 2020 оны 6 дугаар сар),
- 3 дугаар шат: Төгсгөлийн шатны үнэлгээ (хугацаа 2023 оны 12 дугаар сар).

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сумын засаг дарга нар, сумын ИТХ-д болон удирдлагын хороонд мэдээлж тайлагнаж байна. Сумын нийт иргэд, олон нийтэд тайлагнах, мэдээлэх арга хэмжээг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулна. Төлөвлөгөөний биелэлтийн явц, дүн, цаашид авах арга хэмжээний саналыг сумын ИТХ, Засаг дарга нар аймгийн түвшинд мэдээлж байна.

Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан ажлын хэсэг, “Төлөвлөлт, хяналтын хороо”

2014 он 04- сарын 10-ны өдөр

Батлав. Сумын ИТХ-ын 2014 оны
4-р сарын 10-ны өдрийн хуралдаанар

УЛААНХУС СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэх үйл ажиллагааг сумын түвшинд хариуцан төр, захиргааны болон иргэний нийгэмтэй хамтран зохион байгуулж хэрэгжүүлэгч нь олон нийтийн төлөөллийн бүрэлдэхүүн бүхий Төлөвлөлт, хяналтын хороо юм.

Энэхүү журам нь сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагаанд хамаарна.

Зорилго, хэрэгцээ. Сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааг жигд тасалдалгүй явуулах, зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавих, үнэлгээ хийх үйл ажиллагааг сумын Төлөвлөлт, хяналтын хорооноос хариуцан зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Сумын төлөвлөлт, хяналтын хорооны тодорхойлолт, зорилго

Сумын төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн бодлоготой холбоотой асуудлыг хариуцан зангидаж ажиллах төр, захиргааны байгууллага, иргэд, олон нийтийн төлөөллийн орон тооны бус бүтэц мөн.

Төлөвлөлт, хяналтын хорооны ажиллах хугацаа

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулж эхлэх үйл явцаас эхлэн уг төлөвлөгөөг хэрэгжиж дуусах хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулах бөгөөд стратеги төлөвлөгөөний хугацааг сунгах, хугацаа дуусмагц дараагийн шатны төлөвлөгөөг шинээр боловсруулах үед үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна.

Төлөвлөлт, хяналтын хорооны бүтэц, зохион байгуулалт

Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүн, бүтэц, зохион байгуулалтыг Төлөвлөлт, хяналтын хороо өөрийн анхны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хороо нь дотроо суман дахь голлох салбаруудын хөгжлийн асуудлыг хариуцсан ажлын бүлгүүдтэй байна.

Ажлын бүлэг нь 4-өөс доошгүй байх бөгөөд

- эдийн засгийн хөгжлийн ажлын бүлэг
- бизнесийн орчны ажлын бүлэг
- нийгмийн үйлчилгээний ажлын бүлэг
- байгаль, орчны ажлын бүлгүүд заавал байна.

Төлөвлөлт, хяналтын хорооны бүтэц, зохион байгуулалт

Эдийн засгийн тэргүүлэх салбаруудын болон орон нутгийн бусад онцлогийг харгалзан ажлын нэмэлт бүлгүүдийг төрөлжүүлэн байгуулан ажиллуулж болно

Ажлын бүлгүүд нь тус тусдаа гишүүд, ахлагчтай байх бөгөөд тэднийг Төлөвлөлт, хяналтын хорооны дарга уг хорооны бүрэлдэхүүнд оролцогчдоос сонгож ажиллуулна.

Төлөвлөлт, хяналтын хороо нь даргын зэрэгцээ бодлогын хүрээнд үйл ажиллагааг хариуцан зохицуулах нарийн бичгийн даргатай байна.

Төлөвлөлт, хяналтын хороо нь жилд 2-оос доошгүй удаа хуралдаж төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үнэлгээний зэрэг асуудлыг хэлэлцэж байна. Хурлаас тогтоол, тэмдэглэл гаргаж, хурлыг даргалагч гарын үсэг зурж шийдвэрийг баталгаажуулж байна.

Төлөвлөлт, хяналтын хороо нь ажлаа жил жилээр төлөвлөн хэрэгжүүлж ажиллана. Төлөвлөгөөг сумын ИТХ-ын хурал, ЗДТГ-тай санал солилцсоны үндсэн дээр хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд төлөвлөлт, хяналтын хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэн эрх

Төлөвлөлт, хяналтын хороо нь бие даасан байгууллагын хувьд хууль, эрх зүйд нийцсэн шийдвэрийг гаргаж байна.

Гаргасан шийдвэр нь хорооны бүрэлдэхүүний хувьд заавал биелүүлэх баримт бичиг болно.

Төлөвлөлт, хяналтын хороо нь дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:

- Төлөвлөгөөг боловсруулах, түүнд тусгах асуудал, хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцүүлэг зохион байгуулах
- Хөгжлийн бодлого, чиг хандлагатай холбоотой асуудлаар санал, зөвлөмж гаргах
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад түүнийг өөрчлөх, нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулах талаар хамтын шийдвэр гаргах, тэр тухай саналаа ИТХ-д мэдүүлэх, хуралдаанаар хэлэлцүүлэх
- Цаг хугацааны хувьд болон бусад шалтгаанаар хэрэгжих боломжгүй төсөл, асуудлыг төлөвлөгөөнөөс хасахыг санал болгох
- Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой бүхий л асуудлаар ИТХ, ЗДТГ-т зөвлөх эрхтэй

Төлөвлөлт, хяналтын хорооны үүргүүд

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахаас түүнийг хэрэгжиж дуусах хүртэл үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан үүргийг хүлээн ажиллана.

- Төлөвлөгөөг боловсруулахад оролцох
- Төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулах
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавих
- Төлөвлөгөөний төслүүдийн хэрэгжилтийн үнэлгээ хийх
- Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах
- Төлөвлөгөөний биелэлтийг нийтэд мэдээлэх, сурталчлах

Төлөвлөгөөг боловсруулахад оролцох нь

Төлөвлөлт, хяналтын хорооны гол үүргийн нэг нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахад оролцож, оролцооны үнэлгээг олон хэлбэрээр хийх, олон нийтийг хамарсан ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, нөхцөл байдлын судалгаа явуулах зэрэг үйл ажиллагааг бүрэн хариуцан хэрэгжүүлнэ.

Мөн тэдгээрийн үр дүнг нэгтгэн төлөвлөх, төлөвлөгөөний төслийг хянан сайжруулах, ИТХ-д өргөн барих ажиллагааг гардан зохион байгуулж ажиллана.

Төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулах

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл явцыг уг төлөвлөгөөний үндсэн болон хавсралт хэсгүүдэд зааж тодорхойлсны дагуу зохих хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Ингэж ажиллахдаа дараах зарчим, арга хэлбэрийг үндэслэл болгоно. Үүнд:

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан төсөл бүрийг хорооныхоо гишүүдэд хуваарилан хариуцуулж, биелэлтийг дүгнэн мэдээлж байх

Төлөвлөгөөний төсөл бүрийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлон баримталж ажиллах

Төсөл нэг бүрт хувийн хэрэг нээн хөтөлж, зохих баяжуулалт хийж байна

Төсөл бүрийн хөрөнгийг босгох арга гарган бүрдүүлэх

Төслүүдийг хэрэгжүүлэх талаар цаг үеийн болон тусгай компанит ажлууд зохион байгуулах

Төслийг хэрэгжүүлэгчидтэй гэрээ, санамж бичиг байгуулан дүгнэж байх

Голлох аж ахуйн нэгж, байгууллагуудыг хөгжлийн төлөвлөгөөтэй болгох, тэдний төлөвлөгөөнд сумын төлөвлөгөөгөөр тодорхойлсон асуудлуудыг тусгуулах

Албан тушаалтнууд, иргэд, оролцогчдод бүтээлч даалгавар өгч дүгнэн ажиллах

Төслүүдийг хэрэгжүүлэх ажлын явцын талаар хорооны гишүүд, байгууллагын эрх баригч нарын илтгэл, сонсголыг хэлэлцэж чиглэл, шийдвэр гаргах

Хөрөнгө оруулагчид, хандивлагчдын чуулга-уулзалтыг ИТХ, ЗДТГ-тай хамтран үе шаттай зохион байгуулах

Хөрөнгө оруулагчид, хандивлагчдын оруулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үйл явцыг зохион байгуулах

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, зориулагдсан хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүр иргэд, олон нийтэд зориулсан мэдээллийн хуудас гаргаж байх

Төлөвлөгөө, түүний явцыг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байх

Өөрийн мэдээллийн самбар ажиллуулж, мэдээллийг тогтмол шинэчилж байх

Мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор авах зохион байгуулалтын асуудлаар байр сууриа илэрхийлэн зохигчидтой хамтран ажиллах

Төлөвлөгөөнд тодорхойлсон төслүүдийг хэрэгжүүлэхэд бололцоотой дэмжлэг тусалцааг дангаараа болон бусадтай хамтран үзүүлж ажиллах зэрэг болно.

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслүүдийн шалгаруулалтыг хариуцсан төсөл шалгаруулах байнгын багийг хорооныхоо дэргэд байгуулж, төлөвлөгөөнд тодорхойлсон үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөл, хөтөлбөрийн шалгаруулалт зарлах, материалыг хүлээн авах, шалгаруулах үйл ажиллагааг зохицуулж хэрэгжүүлнэ

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавих

Төлөвлөлт, хяналтын хороо нь төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулагч, хариуцагчийн хувьд үр дүнг хянаж байх шаардлагатай.

Хянах үйл явц нь тасалдалгүй байнгын шинжтэй явагдах ёстой.

Хяналтыг голлон хэрэгжүүлэгч нь төлөвлөлт, хяналтын хорооны дарга, ажлын бүлгүүдийн ахлагч нар байна.

Биелэлтийн явцыг хянаж байхад төсөл бүрт нээсэн хувийн хэргийг ашиглаж байна.

Хяналт хийсэн тухай бүрт төслийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийх ба хяналтын үр дүнг төлөвлөлт, хяналтын хорооны буюу ажлын бүлгийн хурлаар хэлэлцэж цаашид авах арга хэмжээг ярилцан тодорхойлж байна.

Хяналтын үйл явцад заавал анхаарвал зохих зүйл бол сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан суманд оруулсан хөрөнгийн зарцуулалт мөн.

Хөрөнгө оруулагчид, хандивлагчид, дэмжигчдээс оруулсан хөрөнгийн тооцоог эх үүсвэр нэг бүрээр гаргаж, тухайн хөрөнгийг юунд, ямар зориулалтаар зарцуулсныг үйл ажиллагаа нэг бүрээр тодорхойлж байна.

Хэрэгжүүлсэн хяналтын үр дүнг өөрийн мэдээллийн самбар, хуудас болон бусад хэрэгслийг ашиглан иргэд, олон нийтэд хүргэж байна.

Төлөвлөгөөний төслүүдийн хэрэгжилтийн үнэлгээ хийх

Төлөвлөлт, хяналтын хорооны үндсэн үүрэгт ажлын чухал хэсэг нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний үнэлгээний асуудал мөн.

Төлөвлөгөөний үнэлгээг хийхдээ түүний хавсралт бүрэлдэхүүн хэсэг болох хяналт үнэлгээний матрицийг үндэслэл болгоно. Тухайлбал төлөвлөгөөний хүрээний төслүүдэд үнэлгээ хийх хугацаа, төсөл бүрийн шалгуур үзүүлэлт, баталгаажилтын эх үүсвэрийн үзүүлэлтүүдийг үнэлгээ явуулахад ашиглана.

Үнэлгээ хийх хугацааг сонгохдоо тухайн төсөл нь хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртлээ дунд шатны болон төгсгөлийн үнэлгээ хийгдсэн байхаар бодох ба харин төсөл хэрэгжиж эхэлсэн эсвэл дууссан эсэхээс үл шалтгаалан төлөвлөгөөний үе шатны бүрийн төгсгөлд үнэлгээг бүрэн хэмжээгээр хийж байна.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь тухайн төслийг хэрэгжсэн гэж үзэх үндэслэл болох тул үнэлгээний дүнг шалгуур үзүүлэлтийн түвшинг хэдий хэмжээгээр, хэдэн хувиар хангаж чадаж байгаагаар тодорхойлно.

Үнэлгээг явуулахдаа бодит баримт материал, судалгааны үр дүнг үндэслэх ба хийсвэр таамгаар үнэлэх явдал гаргаж болохгүй.

Үнэлгээг явуулахдаа хяналт, үнэлгээний багуудыг түр хугацаагаар зохион байгуулж ажиллуулах замаар зохион байгуулна.

Үнэлгээ явуулсан тухай бүр төслийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийж байна. Үнэлгээ хийх явцад болон хийсний дараа цаашид тухайн төслийг хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлыг тодорхойлж байна.

Үнэлгээний хүснэгтийн үзүүлэлтүүд

- Төслийн код, нэр
- Үнэлгээ хийсэн хугацаа
- Үнэлгээний дүн
- Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ

- Тохиолдсон бэрхшээл хүндрэл
- Цаашид авах арга хэмжээ
- Хариуцан зохицуулагч
- Анхаарах хүчин зүйлүүд

Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах

Төлөвлөлт, хяналтын хороо нь жил бүрийн эцэст өөрийн ээлжит хуралдааныг хийж байх бөгөөд төлөвлөгөөний явц, үр дүнг төсөл нэг бүрээр хэлэлцэж байна. Ингэхдээ зайлшгүй өөрчлөх, нэмэлт, сайжруулалт оруулах, төлөвлөгөөнөөс хасах, мөн төлөвлөгөөнд нэмж оруулах шинэ төслүүдийн үндэслэлийг гаргаж, өөрийн санал, байр суурийг илэрхийлсэн тайлбарын хамт ИТХ-д мэдүүлж байна.

ИТХ нь тухайн материалыг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. ИТХ-аар хэлэлцээд тогтоол гарган өөрчлөлтийг баталж байна.

Төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийн талаар иргэд, олон нийтэд мэдээлж байна.

Төлөвлөлт, хяналтын хорооны Төсөв, санхүүгийн зохицуулалт

Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны жилийн зардлыг сумын төсөвт тусган санхүүжүүлнэ.

Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

Тухайн жилийн сумын төсөвт зааж тодорхойлсон эх үүсвэр

Төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нэр зааж өгсөн хандив, тусламж

Бусад

Төлөвлөлт, хяналтын хорооны дарга, нарийн бичгийн даргад тэдний үйл ажиллагааны идэвхитэй байдал, ажлын үр дүнг харгалзан жилд нэг удаа үр дүнгийн урамшуулал олгож байна.

Урамшлыг сумын жил жилийн төсөвт тусгана.

Төлөвлөлт, хяналтын хорооны шугамаар зохиогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ, судалгаа болон төрөл бүрийн бусад ажиллагаанд ИТХ, ЗДТГ-ыг болон ТХХ-ны шийдвэрээр томилогдож оролцсон гишүүдэд тухай бүр нь зохих урамшуулал олгох асуудлыг тухайн байгууллагууд хариуцан зохицуулж байна.

Хариуцсан төслүүдээ хугацаанд нь амжилттай сайн хэрэгжүүлж байгаа хорооны гишүүд, ажлын бүлгийн ахлагч нарт зохих урамшил олгож байна.

Онцгой ач холбогдолтой төслийг амжилттай хэрэгжүүлсэн хорооны гишүүнийг төслийн эдийн засгийн үр ашгаас хувь олгох байдлаар хэрэгжүүлэгчтэй холбон ажиллуулж болно.

Төлөвлөлт, хяналтын хорооны шугамаар зохиогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ, судалгаа болон төрөл бүрийн бусад ажиллагаанд ИТХ, ЗДТГ-ыг болон ТХХ-ны шийдвэрээр томилогдож оролцсон гишүүдэд тухай бүр нь зохих урамшуулал олгох асуудлыг тухайн байгууллагууд хариуцан зохицуулж байна.

Хариуцсан төслүүдээ хугацаанд нь амжилттай сайн хэрэгжүүлж байгаа хорооны гишүүд, ажлын бүлгийн ахлагч нарт зохих урамшил олгож байна.

Онцгой ач холбогдолтой төслийг амжилттай хэрэгжүүлсэн хорооны гишүүнийг төслийн эдийн засгийн үр ашгаас хувь олгох байдлаар хэрэгжүүлэгчтэй холбон ажиллуулж болно

Хяналт, үнэлгээний баг, түүний үйл ажиллагаа

Төлөвлөлт, хяналтын хороо нь сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний биелэлтийн байдалд хяналт тавих, үнэлгээ хийх үйл явцаа хэрэгжүүлэхдээ хяналт, үнэлгээний багийг байгуулан ажиллуулах байдлаар хэрэгжүүлнэ.

Хяналт, үнэлгээний баг нь өргөн, дунд, анхан шатны гэсэн 3 шатлалын бүтэцтэй байна.

